



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал Судалгааны тайлан

МУИС-ийн Нийгмийн Судалгааны Хүрээлэн
Авлигын нөхцөл байдлын судалгаа: өөрчлөлт хандлага
2025 он

АГУУЛГА

Товчлол.....	2
Зураг, дүрслэлийн жагсаалт.....	3
Хүснэгтийн жагсаалт.....	5
ОРШИЛ.....	6
СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН.....	7
СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ.....	14
БҮЛЭГ 1. ТҮҮВРИЙН ТАНИЛЦУУЛГА.....	16
БҮЛЭГ 2. БИЗНЕСИЙН ОРЧИН.....	22
БҮЛЭГ 3. БИЗНЕСИЙН ОРЧНЫ СААД БЭРХШЭЭЛ.....	32
БҮЛЭГ 4. АЛДАГДАЛ БУЮУ ҮР АШИГГҮЙ ЗАРЦУУЛАЛТ.....	37
БҮЛЭГ 5. ТӨРИЙН АЛБАН ДАХЬ АВЛИГА.....	44
БҮЛЭГ 6. ХУВИЙН ХЭВШИЛ ДЭХ АВЛИГА.....	55
БҮЛЭГ 7. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	61

Товчлол

ААН	Аж ахуйн нэгж
АНУ	Америкийн нэгдсэн улс
АТГ	Авлигатай тэмцэх газар
АТИ	Авлигын төсөөллийн индекс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
МУ	Монгол улс
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
МУИС	Монгол Улсын Их Сургууль
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын их хурал
ХАА	Хөдөө аж ахуй

Зураг, дүрслэлийн жагсаалт

Зураг 1.1. Судалгаанд оролцогч аж ахуйн нэгжүүдийн хуваарилалт /газар зүйн байршлаар/

Зураг 1.2. Судалгаанд оролцогч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл

Зураг 1.3. Жилийн эргэлтийн хөрөнгийн хэмжээ

Зураг 1.4. Үүсгэн байгуулагдсан он

Зураг 1.5. Компанийн ажилчдын хүйсийн харьцаа

Зураг 1.6. Компанийн үйл ажиллагааны чиглэл, хүйсийн бүтэц

(Зураг 2.1.) Аж ахуй эрхлэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ бүхэлдээ 2025 онд сайнгүй байна.

Зураг 2.2. Бизнесийн орчны сэтгэл ханамжийн үнэлгээний дундаж. Он оноор харьцуулсан үзүүлэлт (Бизнесийн орчны үнэлгээний дундаж (маш сэтгэл хангалуун* +2, харьцангуй сэтгэл хангалуун* +1, бага зэрэг сэтгэл хангалуун бус* -1, огт сэтгэл хангалуун бус* -2))

Зураг 2.3. Бизнесийн орчны сэтгэл ханамжийг компанийн хэмжээгээр харьцуулсан шинжилгээ

Зураг 2.4. Бизнесийн орчны сэтгэл ханамжийн дунджийг компанийн хэмжээ болон он оноор харьцуулав

Зураг 2.5. Бизнесийн орчны сэтгэл ханамжийг компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, салбараар харьцуулсан шинжилгээ

Зураг 2.6. Бизнесийн орчны сэтгэл ханамжийн үнэлгээг хүйсээр харьцуулав

Зураг 2.7. Бизнес аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбоотой сүүлийн 1 жилийн хөрөнгө оруулалтын байдал

Зураг 2.8. Бизнес аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбоотой ирэх жилүүдийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хүлээлт

Зураг 2.9. Хөрөнгө оруулалтын байдлыг салбараар харьцуулан үзэхэд

Зураг 2.10. Хөрөнгө оруулалт болон компанийн хэмжээ хоорондын хамаарлын статистик шинжилгээний Хи2 үнэлгээний дүн

Зураг 2.11. Компанийн хөрөнгө оруулалт болон хөрөнгө оруулалтын харьцааны

Зураг 3.1. Бизнесийн орчны хамгийн том саад бэрхшээлийг 2018 болон 2025 оны нөхцөлөөр харьцуулан илэрхийлэх байдал

Зураг 3.2. Бизнес эрхлэхэд нь хамгийн их саад, дарамж болдог байгууллага

Зураг 4.1. Бизнес эрхлэлттэй холбоотой үйлдвэрлэлийн бус асуудлыг шийдвэрлэхэд зарцуулдаг ажлын цаг

Зураг 4.2. Бизнес эрхлэлттэй холбоотой үйлдвэрлэлийн бус асуудлыг шийдвэрлэхэд зарцуулдаг ажлын хувь

Зураг 4.3. Бизнес эрхлэлттэй холбоотой (үйлдвэрлэлийн бус асуудал шийдэх) төрөөс үйлчилгээ авахад зарцуулдаг байгууллагын хөрөнгө нөөцийн хувь

Зураг 4.4. Бизнес эрхлэлттэй холбоотой (үйлдвэрлэлийн бус асуудал шийдэх) төрөөс үйлчилгээ авахад зарцуулдаг байгууллагын хөрөнгө нөөцийн хувь хэмжээ

Зураг 5.1. Төрийн албаны авлигын хэмжээг үнэлэх байдал

Зураг 5.2. Таны бодлоор төрийн албанд авлига хэр их байна вэ?

Зураг 5.3. Бизнесийн салбарт аль нэгэн компани төрийн байгууллагад авлига өгсөн тохиолдол

Зураг 5.4. Төрийн худалдан авах ажиллагаа (тендер) болон гэрээ байгуулах ажиллагаанд авлига тохиолддог эсэх талаарх асуудал

Зураг 5.5. Төрийн албан дахь авлига бизнест нь нөлөөлж байгаа эсэх

Зураг 5.6. Засгийн газраас сүүлийн 2 жилд хэрэгжүүлж буй авлигын эсрэг үйл ажиллагааны талаар хэр сайн мэдэх вэ?

Зураг 5.7. Өмнөх Засгийн газрын хэрэгжүүлж байсан авлигын эсрэг арга хэмжээ Монгол улсын авлигыг бууруулахад хэр үр дүнтэй байсан вэ?

Зураг 5.8. Засгийн газраас хэрэгжүүлж буй авлигын эсрэг арга хэмжээний дүнд танай салбарын авлигын орчин нэг жилийн өмнөхтэй харьцуулбал хэр өөрчлөгдсөн бэ?

Зураг 5.9. Таны бодлоор Бизнесийн орчныг ил тод, авлигаас ангид болгоход хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжууд хэр үр нөлөөтэй байна вэ?

Зураг 5.10. Авлигад өртсөн төрийн албан тушаалтнуудад Засгийн газар бодитой, шударгаар хариуцлага тооцож чаддаг уу?

Зураг 5.11. Өндөр албан тушаалтны мөнгөн дүн ихтэй авлига таны бизнест хэр зэрэг нөлөөлж байна вэ?

Зураг 5.12. Өндөр албан тушаалтны мөнгөн дүн ихтэй авлига таны бизнест хэр зэрэг нөлөөлж байна вэ?

Зураг 5.13. Таны бодлоор төрийн авлига хувь хүмүүсийн хоорондын харилцааны хүрээнд эсвэл зохион байгуулалттай бүлэглэлийн хэмжээнд очсон уу?

Зураг 6.1. Хувийн хэвшлийн салбарт авлига ямар байгааг үнэлсэн үнэлгээ

Зураг 6.2. Тендер болон гэрээ байгуулахад авлига байгааг үнэлсэн үнэлгээ

Зураг 6.3. Татвараа хууль ёсны дагуу төлөх байдлын үнэлгээ

Зураг 7.1. Авлигын хэрэгт хариуцлага тооцон талаарх санаа бодол

Зураг 7.2. Төрийн авлигын бизнес дэх нөлөө

Зураг 7.3. Авлигын эсрэг хийж буй ажил

Зураг 7.4. Авлигын талаар мэдээлэл өгөх

Зураг 7.5. Мэдээллийн үр өгөөж

Зураг 7.6. Авлигатай тэмцэх журам, бодлого байгаа эсэх

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.1. Байгууллагын ажилчдын хүйсийн харьцаа

Хүснэгт 3.1. Байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон бизнест хамгийн их саад бэрхшээл учруулдаг байгууллагын харьцуулсан хүснэгт

Хүснэгт 4.1. Бизнес эрхлэлттэй холбоотой (үйлдвэрлэлийн бус асуудал шийдэх) ажлын хэдэн хувийг зарцуулдаг вэ?

Хүснэгт 4.2. Бизнес эрхлэлттэй холбоотой үйлдвэрлэлийн бус асуудлыг шийдвэрлэхэд ажлын хэдэн хувийг зарцуулдаг вэ?

Хүснэгт 4.3. Бизнес эрхлэлттэй холбоотой (үйлдвэрлэлийн бус асуудал шийдэх) төрөөс үйлчилгээ авахад байгууллагын хөрөнгө нөөцийн хэдэн хувийг зарцуулдаг вэ?

Хүснэгт 4.4. Бизнес эрхлэлттэй холбоотой (үйлдвэрлэлийн бус асуудал шийдэх) төрөөс үйлчилгээ авахад байгууллагын хөрөнгө нөөцийн хэдэн хувийг зарцуулдаг вэ?

Хүснэгт 5.1. Таны бодлоор төрийн албанд авлига хэр их байна вэ?

Хүснэгт 5.2. Таны бодлоор төрийн албанд авлига хэр их байна вэ?

Хүснэгт 5.3. Танай бизнесийн салбарт аль нэгэн компани төрийн байгууллагад авлига өгсөн тохиолдол байна уу?

Хүснэгт 5.4. Танай бизнесийн салбарт аль нэгэн компани төрийн байгууллагад авлига өгсөн тохиолдол байна уу?

Хүснэгт 6.1 Хувийн хэвшил дэх авлигын түвшнийг хүснэгтээр давхар харууллаа.

Хүснэгт 6.2. Хувийн хэвшлийн тендерийн болон гэрээ байгуулах ажиллагаа дах авлигын түвшин

Хүснэгт 6.3. Бизнесийн салбаруудад үйл ажиллагаа явуулахад тохиолдох авлига

Хүснэгт 7.1. Бизнесийн байгууллагын авлигын эсрэг хийж байгаа ажил

Хүснэгт 7.2. Авлигатай тэмцэх дотоод журам, бодлого бий эсэх

Хүснэгт 7.3. Бизнесийн орчин дахь авлигын эсрэг үйл ажиллагаа

ОРШИЛ

Энэ судалгааг Авлигатай тэмцэх газрын захиалгаар Монгол Улс дахь бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал, үр дагавар, бизнес эрхлэгчдийн авлигын эсрэг хандлага, ойлголтыг тодорхойлох зорилгоор МУИС-ийн Нийгмийн судалгааны хүрээлэнгийн судлаачдын баг гүйцэтгэлээ. Судалгааны зорилго нь Монгол Улсын бизнесийн орчин дахь авлигаас үүдэлтэй нөхцөл байдал, бизнес эрхлэгчдийн ойлголт, авлигаас урьдчилан сэргийлэх талаарх төсөөллийг судалж, сайн засаглалын туршлагыг бэхжүүлэхэд шаардлагатай мэдээллийн санд хувь нэмэр оруулахад оршиж байна.

Судалгаа нь гурван зуу гаруй хувийн хэвшлийн ахуйн нэгжийн төлөөллийг хамруулан санал асуулгын аргаар мэдээлэл цуглуулж, агуулгын хувьд бизнесийн орчин, бизнесийн орчны саад бэрхшээл, алдагдал буюу үр ашиггүй зарцуулалт, төрийн алба болон хувийн хэвшил дэх авлига, авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаарх бизнес эрхлэгчдийн төсөөллийг судалсан юм.

Энэхүү судалгаа нь сүүлийн арав гаруй жилийн хугацаанд Азийн Сан, Сант Марал Сан хамтран хийсэн судалгаануудын үргэлжлэл бөгөөд бизнес эрхлэлтийн орчин дахь авлигаас үүдэлтэй нөхцөл байдлын өөрчлөлт, чиг хандлагыг тодорхойлох боломжийг олгож байна. Өмнөх судалгааны асуумж, аргачлалыг сайжруулж, засварлан ашиглалаа. Авлигатай тэмцэх газраас захиалан хэрэгжүүлсэн энэ удаагийн судалгаа нь цаашид урт хугацаанд үргэлжлэн тогтмол хэрэгжих, шаардлагатай судалгааны үргэлжлэл болж буйг тэмдэглэхийн зэрэгцээ, Монгол улс дахь бизнесийн орчны авлигын нөхцөл байдлыг тусган харуулж чадсан. Энэ нь Монгол Улсын бизнес эрхлэлт болон засаглалын орчинд авлигын нөлөөг нарийвчлан тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэж, хэрэгжүүлсэн судалгааны аргачлал, дүн шинжилгээ нь авлигын эсрэг бодлого боловсруулахад дэмжлэг болно гэдэгт судалгааны баг итгэж байна.

Судалгааг амжилттай хэрэгжүүлэхэд удирдлага зохион байгуулалт, мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлж, судалгааны багтай нягт хамтран ажилласан АТГ-ын Судалгаа шинжилгээний албаны удирдлага, судлаач, шинжээчдэд талархал илэрхийлье.

СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН

Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал” судалгааны гол үр дүнгүүдийг дараах байдлаар танилцуулж байна.

- Бизнес эрхлэгчдийн бизнесийн орчны талаарх сэтгэл ханамж нь тухайн улсын бизнесийн бодлого, эрх зүйн орчин болон түүний хэрэгжилт, эдийн засгийн эрх чөлөөний боломж, төрийн оролцоо зохистой эсэх, эдийн засгийн бүтэц, банк санхүүгийн зах зээлийн хөгжил зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг.
- Ерөнхий дүнгээр авч үзвэл, бизнесийн орчны талаарх сэтгэл ханамжийн түвшин сөрөг үнэлгээ давамгайлж байна. Тухайлбал, 2025 оны 9-р сард хийсэн энэ удаагийн судалгааны үр дүнгээр бизнес эрхлэгчдийн сэтгэл ханамжгүй байдлын түвшин 2016, 2017, 2018 онуудын дундаж үзүүлэлттэй харьцуулахад өссөн байна.
- Том компаниуд бизнесийн орчны талаар илүү сэтгэл дундуур байх хандлагатай байна. Компанийн хөрөнгийн эргэлттэй харьцуулбал, том хэмжээний компаниудын бизнесийн орчинтой холбоотой сэтгэл ханамжийн байдал нь жижиг, дунд хэмжээтэй компаниудаас илүү сөрөг байх нь ажиглагдлаа.
- Бизнесийн орчны чанарын үнэлгээний нэг гол хэсэг нь сэтгэл ханамжийн судалгаа байдаг бөгөөд судалгаанд оролцогчдын сэтгэл ханамж ерөнхийдөө доогуур буурсан (15 хувь) хандлагатай байна. Судалгааны үр дүнгээс харахад, 2012-2018 оны хооронд бизнесийн орчны талаарх сэтгэл ханамж "бага зэрэг хангалуун" гэсэн дундаж үнэлгээ давамгайлж байсан бол 2025 онд энэ байдал эрс өөрчлөгджээ. Уг өөрчлөлт нь Монголын бизнесийн орчин хүндэрч, бизнес эрхлэгчдийн итгэл суларсныг илтгэж байна.
- Судалгааны үр дүнгээс харахад компанийн хэмжээ томрох тусам бизнесийн орчны талаарх сэтгэл ханамж буурах хандлагатай байна. Энэ нь том компаниуд илүү өндөр хүлээлттэй байдаг төдийгүй зохицуулалтын олон талт дарамтад өртөх магадлал өндөр байгааг илтгэж байна. Иймд бодлого боловсруулахдаа компанийн хэмжээнээс хамаарах ялгаатай нөхцөл, шаардлагыг онцгойлон тооцох нь зүйтэй.
- Салбарын түвшинд авч үзвэл үйлдвэрлэл болон үйлчилгээний салбар хамгийн их сөрөг хандлагатай байгааг судалгаа харуулж байна. Үйлчилгээний салбарын 67 хувь, үйлдвэрлэлийн салбарын ихэнх компаниуд бизнесийн орчинд “ сэтгэл хангалуун бус” байр суурь илэрхийлсэн байна. Харин худалдааны салбарынхан харьцангуй илүү эерэг үнэлгээтэй (75 хувь) байсан ч нийт дүнгээрээ бизнесийн орчинд сөрөг хандлагатай хэвээр байна. Энэ нь салбар бүр өөрийн онцлог,

тулгамдсан асуудалтай байгааг харуулж байгаа бөгөөд нийтлэг, нэг төрлийн бодлогоос гадна салбарын онцлогт нийцсэн бодлогын шийдэл зайлшгүй шаардлагатайг илтгэж байна.

- Үйлчилгээний салбарын хувьд, хууль эрх зүйн орчны тогтворгүй байдал, лиценз, зөвшөөрөлтэй холбоотой төвөгтэй журам, татварын өндөр дарамт, санхүүгийн хүртээмжийн хомсдол зэрэг асуудлууд нэн түрүүнд шийдвэрлэх шаардлагатай байна. Энэ салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын хувьд хөрөнгө оруулалт татах, шинэ үйлчилгээ нэвтрүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах орчин ойлгомжтой, тогтвортой байх нь чухал гэжээ.
- Үйлдвэрлэлийн салбарын хувьд, технологийн хоцрогдол, мэргэшсэн боловсон хүчний хомсдол, зах зээлийн хязгаарлагдмал байдал, зээлийн нөхцөл хүнд байгаа нь бизнесийн орчны сэтгэл ханамжийг бууруулж байна. Иймд энэ салбарт технологийн шинэчлэлийг дэмжих, инновацийг нэвтрүүлэхэд чиглэсэн бодлого, мэргэшсэн хүний нөөцийн бэлтгэл, санхүүгийн уян хатан дэмжлэгийн механизмыг бий болгох шаардлагатай.
- Худалдааны салбарын хувьд, харьцангуй эерэг байр суурьтай байгаа нь зах зээлийн өргөн хүрээтэй байдал, хэрэглэгчийн эрэлт тогтвортой, төрийн зохицуулалтын хүчин зүйлтэй холбоотой байж болох юм. Гэсэн хэдий ч нийт дүнгээрээ сөрөг үнэлгээ өндөр байгаа нь тус салбар ч мөн адил тодорхой өөрчлөлт, дэмжлэг шаардлагатайг харуулж байна. Ерөнхий дүгнэлтээр, бизнесийн орчны сэтгэл ханамжийг дээшлүүлэхийн тулд салбар бүрийн онцлог, тулгамдсан асуудлыг нарийвчлан судалж, тэдгээрт нийцсэн бодлого хэрэгжүүлэх шаардлагатай нь харагдаж байна. Ингэснээр бизнесийн орчны тогтвортой байдал нэмэгдэж, компаниудын сэтгэл ханамж дээшилж, эдийн засгийн өрсөлдөх чадвар цаашид сайжрах боломжтой юм.
- Бизнесийн орчныг хязгаарлаж буй гол бэрхшээлүүдийн нэг нь зөвшөөрөл, хяналт шалгалтын давхардал болон бодлогын тогтворгүй байдал юм. Эдгээр хүчин зүйл нь бизнесийн зардлыг өсгөж, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах үйл явцыг удаашруулж байна. Төрийн үйлчилгээний процесс удаан, ил тод бус, олон давхардалтай хэвээр байгаа нь зохицуулалтын хэрэгжилт болон төрийн байгууллагуудын уялдаа холбоо хангалтгүй байгааг харуулдаг. Сүүлийн жилүүдэд зөвшөөрөл, лицензийн тоог бууруулах, цахимжуулах бодлого хэрэгжиж байгаа ч хэрэгжилтийн шатанд үр өгөөж нь жигд бус байгаа бөгөөд тогтмол өөрчлөгдөж буй дүрэм журам, агентлаг хоорондын зөрүүтэй шаардлага нь хугацаа болон санхүүгийн өртгийг нэмэгдүүлж, ялангуяа жижиг, дунд бизнес эрхлэгчдэд илүү их дарамт учруулж байна
- Авлига нь бизнес эрхлэгчдийн хувьд хууль ёсны бус нэмэлт зардал бөгөөд эдийн засгийн эрх чөлөөг шударга бусаар хязгаарлаж буй нэг гол хүчин зүйл юм. Үүний улмаас компаниуд болон бизнес эрхлэгчид бизнесийн үйл

ажиллагаандаа зарцуулах ёстой цаг хугацаа, хөрөнгө, нөөцөө хүнд суртал, чирэгдлийг даван туулахад зориулж, бизнесийн өрсөлдөх чадвар, хөгжилд сөргөөр нөлөөлж байна.

- Сүүлийн арван жилийн хугацаанд бизнесийнхэн үйлдвэрлэлийн бус асуудлуудыг шийдвэрлэхэд зарцуулах цаг нь тодорхой хэмжээнд буурсан байна. Тодруулбал, бизнесийн цагийг энэ төрлийн асуудалд огт зарцуулаагүй гэх хариулт сүүлийн арван жилд 1.4 хувиар, сүүлийн зургаан жилд 1.8 хувиар тус тус буурчээ. Энэ нь бизнесийн орчин сайжирч, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд илүү төвлөрөх боломжтой болж байгааг харуулж байна.
- 2025 оны судалгаагаар бизнес эрхлэгчдийн 13.4 хувь нь үйлдвэрлэлээс бусад буюу бизнесийн үйл ажиллагаатай шууд холбоогүй асуудалд огт цаг зарцуулдаггүй гэж хариулсан байна. Үүний зэрэгцээ 30 хувь нь нийт цагийнхаа 25 хүртэл хувийг, 14.6 хувь нь 25–50 хүртэл хувийг, 8 хувь нь 50-иас дээш хувийг ийм асуудалд зарцуулж буй нь бизнесийн үндсэн үйл ажиллагаанаас гадуурх ачаалал тодорхой хэмжээгээр өндөр байгааг харуулж байна.
- Компаниудын эргэлтийн хөрөнгийн хэмжээ бага байх тусам дээрх ажилд бизнесийн ажлын цагаас огт зарцуулдаггүй бүлгийн хувь хэмжээ илүү хувьтай байгаа ба эсрэгээр эргэлтийн хөрөнгийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр цаг хугацааны алдагдал гаргах хандлага нэмэгдэж байна.
- Салбарын түвшинд тодорхой ялгаа гарч байгааг судалгаа харуулж байна. Жишээлбэл, худалдааны салбарын компаниуд ажлын цагийнхаа 25 хүртэл болон 25–50 хүртэл хувийг үйлдвэрлэлтэй холбоогүй асуудалд зарцуулдаг нь харьцангуй өндөр үзүүлэлттэй байна. Харин барилга угсралтын салбарын хувьд 25 хүртэл хувийг зарцуулдаг нь хамгийн түгээмэл хандлага болжээ. Энэ нь тухайн салбаруудад бизнес эрхлэхтэй холбоотой төрийн үйлчилгээний шат дамжлага, чирэгдэл болон тусгай зөвшөөрөлтэй холбоотой хүндрэлүүдийн хэмжээг тусган харуулж болох юм.
- Сүүлийн арав гаруй жилийн хугацаанд бизнесийн байгууллагын хөрөнгө нөөцийн 25 хүртэлх хувийг төрөөс үйлчилгээ авахтай холбоотой зардалд зарцуулдаг хэсгийн хэмжээ тогтвортой буурсаар иржээ. Харин түүнээс илүү их өртөг зардлыг төлж буй бизнес эрхлэгчдийн хувь хэмжээнд өөрчлөлт гараагүй байна.
- Судалгааны дүнгээс харахад төрийн үйлчилгээ авахын тулд байгууллагын хөрөнгийн тодорхой хэсгийг зарцуулах байдал буурах хандлагатай байна. Тухайлбал, 2012 онд нийт хөрөнгийн 10 хүртэл хувийг зарцуулдаг гэж хариулсан бүлэг 36.4 хувь байсан бол 2025 онд 27.4 хувь болж буурсан байна. Мөн нийт хөрөнгийн 10–25 хувийг зарцуулдаг гэж хариулсан бүлэг 2012 онд 22.1 хувь байсан бол 2025 онд 13.1 хувь болж буурсан нь энэ чиг хандлагыг баталж байна.

- Бизнес эрхлэгчдийн төрөөс үйлчилгээ авахдаа зарцуулах өртөг зардал байгууллагын үйл ажиллагааны чиглэлээс хамааран онцлон үзэх ялгаа байхгүй байна. Харин тэдний төрөөс үйлчилгээ авахдаа зарцуулах өртөг зардал байгууллагын эргэлтийн хөрөнгийн хэмжээнээс хамааран ялгаатай байна. Жишээлбэл 300 саяас нэг тэрбум төгрөгийн хөрөнгөтэй дунд хэмжээний байгууллагуудын хувьд 10 хувиас доош зарцуулдаг нь хамгийн өндөр (36.6 хувь) байхад 2.5–5 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй байгууллагуудын дунд 25 хувиас дээш зарцуулж буй нь 9.7 хувь хүрч, бусдаас хамгийн өндөр хувьтай байна.
- Судалгааны үр дүнгээс харахад сүүлийн арван жилийн хугацаанд төрийн албаны авлигын талаарх бизнес эрхлэгчдийн төсөөлөлд эерэг хандлага ажиглагдаж байна. 2015 онд “төрийн албанд авлига маш их бий” гэж үзсэн бизнес эрхлэгчдийн хувь 50 байсан бол 2025 онд 26 хувь болж буурсан нь энэ чиг хандлагын бодит илрэл юм. Энэ нь өмнөх арван жилийн хамгийн өндөр үзүүлэлттэй харьцуулахад мэдэгдэхүйц буурсан үзүүлэлт бөгөөд бизнесийн орчин дахь авлигын талаарх ойлголт, үнэлэмжид эерэг өөрчлөлт гарч байгааг харуулж байна.
- Бизнес эрхлэгчдийн төрийн албан дахь авлигын талаарх төсөөлөл тэдний эргэлтийн хөрөнгийн хэмжээгээр өөр буюу энэ нь ихсэх тусам төрийн албанд "маш их" авлига байна гэж үзсэн хариултын хувь нэмэгдэж байна. Жишээлбэл нэг тэрбум төгрөгөөс дээш хөрөнгийн эргэлттэй бүлгийн хувьд авлига "нэлээд байдаг" гэсэн хариулт эрс нэмэгдэж 40 хувиас дээш гарч, хамгийн их хөрөнгө эргэдэг бүлэгт 50 хувьд хүрч байгаа юм. Хөрөнгийн хэмжээ өсөх тусам тэд илүү их авлигын эрсдэлтэй тулж байж болох юм.
- Салбарын түвшинд авч үзвэл, барилга болон уул уурхайн салбарын бизнес эрхлэгчид төрийн албыг илүү өндөр түвшний буюу 70 орчим хувь нь авлигатай гэж үнэлсэн байна. Харин бусад салбарын хувьд бизнес эрхлэгчдийн ойролцоогоор 50 хувь нь төрийн албыг авлига ихтэй гэж үзэж байна
- 2012, 2015, 2018 болон 2025 онуудад бизнес эрхлэгчдийн зүгээс төрийн байгууллагад авлига өгөх тохиолдол тогтмол буурч, 2025 онд 5.2 хувьд хүрсэн байна. Энэ нь бизнесийн салбар дахь авлигын тохиолдлын хэмжээний бууралтыг тодорхой харуулж байна. Сүүлийн жил гаруй хугацаанд авлигын цар хүрээ ойрын мөчлөг буюу сүүлийн хэдэн сард эрс багассан нь эерэг хандлагын илэрхийлж байна. Гэсэн хэдий ч үйлчилгээ, худалдаа, үйлдвэрлэлийн салбаруудад авлигын тохиолдол ойрын хугацаанд илэрсээр байгаа бол барилга угсралт болон уул уурхайн салбаруудад авлигын тохиолдол илрэх хугацаа харьцангуй алсарч, өмнөх нэг жил болон түүнээс цааших хугацаанд хамаарах нь ажиглагдаж байна.
- Харин дунд болон харьцангуй том хэмжээний хөрөнгийн эргэлттэй байгууллагуудын хувьд авлигын тохиолдол илүү түгээмэл байгааг харуулж байна. Томоохон компаниудын хувьд хөрөнгийн эргэлтийн хэмжээ өндөр

байдаг тул тэдний дурсаж буй авлигын тохиолдол ихэвчлэн нэг жилийн өмнөх хугацаатай холбоотой байна.

- Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд төрийн худалдан авах ажиллагааны хүрээнд авлигын тохиолдол буурч буй нь тогтвортой хандлага болж байна. Ялангуяа худалдан авах ажиллагаа болон гэрээ байгуулах үйл явцад авлига тогтмол тохиолддог гэж үзсэн бизнес эрхлэгчдийн хувь 2012 онд 47 байсан бол 2025 онд 20.5 болж, бараг хоёр дахин буурсан нь авлигын талаарх ойлголтод эерэг өөрчлөлт гарсныг харуулж байна.
- Бизнес эрхлэгчдийн төсөөллөөр төрийн албан дахь авлигын бизнест үзүүлэх шууд нөлөө 2012–2015 онд өндөр байсан бол энэ хандлага 2018 оноос буурч эхэлсэн төдийгүй, тэдний бизнест шууд нөлөө үзүүлэхгүй гэх нь давамгайлж иржээ.
- Бизнес эрхлэгчдийн 40 орчим хувь нь сүүлийн жилүүдэд Засгийн газраас хэрэгжүүлсэн авлигын эсрэг бодлого, үйл ажиллагаа үр нөлөөгүй байсан гэж үнэлжээ. Мөн бизнес эрхлэгчдийн дунд энэ төрлийн бодлого, арга хэмжээний талаарх мэдээлэл, мэдлэг дутмаг байгаа нь ажиглагдаж байна.
- Бизнес эрхлэгчдийн зүгээс Монгол Улсад өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй авлигын эсрэг хууль тогтоомжуудын үр нөлөө хангалтгүй байна гэсэн төсөөлөл давамгайлж байна. Судалгаанд оролцогчдын 20 гаруй хувь нь эдгээр хууль тогтоомж огт үр нөлөөгүй гэж үзсэн бол 36.5 хувь нь “бага зэрэг үр нөлөөтэй” гэж үнэлжээ.
- Бизнес эрхлэгчдийн талаас илүү хувь буюу 51 хувь нь Засгийн газар авлигын хэрэгт холбогдсон өндөр албан тушаалтнуудтай бодитой, шударга хариуцлага тооцож чадахгүй байна гэж үзсэн байна. Гэвч өндөр түвшний авлига бизнесийн үйл ажиллагаанд хүчтэй нөлөөлж байна гэсэн ойлголт сүүлийн арван жилд буурсан байна. Тухайлбал, арван жилийн өмнө бизнес эрхлэгчдийн 45 хувь нь “маш их” эсвэл “их” нөлөөтэй гэж үзэж байсан бол өнөөдөр энэ үзүүлэлт 25 хувь болж буурчээ. Харин огт нөлөөгүй гэж үзсэн бүлгийн хувь хэмжээ 13 хувиар нэмэгдсэн байна.
- Хувийн хэвшлийн салбарт авлигын түвшний талаарх ойлголт мөн өөрчлөгдөж байна. 2018 онд хийсэн судалгаанд оролцогчдын 27.6 хувь нь хувийн хэвшилд авлига байхгүй гэж үзэж байсан бол 2025 онд энэ үзүүлэлт 16.6 хувь болж буурсан нь авлига бизнесийн салбарт нэмэгдэх хандлагатай байгааг илтгэж байна. Өөрөөр хэлбэл, 2018 оныхоос “авлига байхгүй” гэсэн хариултын хувь 9 нэгжээр буурсан байна. Мөн бизнесийн салбарт “авлига маш их/их байна” гэсэн үнэлгээ 2018 онд 26.6 хувь байсан бол 2025 онд 33.7 хувь болж, 7.1 нэгжээр өссөн байна.
- Төрийн албан дахь авлигын цар хэмжээний талаарх бизнес эрхлэгчдийн төсөөлөл харьцангуй буурсан бол хувийн хэвшил дэх авлигын талаарх төсөөлөл эсрэгээр нэмэгдсэн байна. Тухайлбал, хувийн хэвшилд авлига ихээхэн хэмжээгээр байна гэж үзсэн бизнес эрхлэгчдийн хувь 2016 оныхоос 15 орчим нэгжээр, 2018 оныхоос 7 гаруй нэгжээр өсжээ.

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

- Судалгаанд оролцогчдын 39 орчим хувь нь хувийн хэвшлийн салбарт тендерийн болон гэрээ байгуулах үйл ажиллагаанд авлига нэлээд түгээмэл байна гэж үзсэн бөгөөд энэ үзүүлэлт сүүлийн арван жилд хамгийн өндөр түвшинд хүрчээ.
- Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд аль аль талд хариуцлага тооцох тухайд санал бодол хуваагддаг боловч судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн дийлэнх буюу 75.4 хувь нь төрийн байгууллага болон хувийн хэвшил аль алинд нь хариуцлага тооцох ёстой гэж үзсэн байна.
- Сүүлийн арван жилийн судалгааны дүнгээс харахад төрийн албан дахь авлигын хэмжээ буурвал бизнесийн орчинд эергээр нөлөөлж, тухайлбал орлого нэмэгдэх боломжтой гэсэн хүлээлт бизнес эрхлэгчдийн дунд тогтвортой хадгалагдаж ирсэн байна. Энэ нь бизнес эрхлэгчдийн хамгийн гол хүлээлтийн нэг хэвээр байна.
- Бизнесийн орчныг сайжруулахад авлигатай тэмцэх нь гол чиглэлүүдийн нэг боловч компаниудын оролцоо хангалтгүй байгаа нь судалгаагаар тогтоогджээ. Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн талаас илүү хувь (54.6%) нь өөрийн байгууллага авлигын эсрэг ямар нэгэн ажил огт хийдэггүй гэж хариулсан байна.
- Үүнтэй холбогдуулан нэг асуудал нь компаниуд авлигыг үл тэвчих байр суурьтай байх, аливаа авлига, ашиг сонирхлын зөрчлийн тохиолдлыг илрүүлсэн тохиолдолд холбогдох төрийн байгууллагад мэдээлэх үүрэгтэй холбоотой. Судалгаанд оролцогчдын дөнгөж 10 хувь нь ийм тохиолдолд төрийн байгууллагад хандсан гэж хариулсан бол 58 хувь нь огт хандаж байгаагүй, харин гурван бизнес эрхлэгч тутмын нэг нь “мэдэхгүй” гэж хариулсан нь нийтлэг идэвхгүй байр суурийг илэрхийлж байна.
- Судалгаанд оролцсон компаниудын 27 орчим хувь нь дотооддоо авлигатай тэмцэх бодлого буюу тодорхой журамтай гэж хариулсан бол 46 хувь нь огт байхгүй, харин 24 хувь нь ийм бодлого, журам байгаа эсэхээ мэдэхгүй байна.
- Бизнес эрхлэгчид авлигатай тэмцэх, түүнийг бууруулахад хамгийн чухал арга хэмжээг дараах байдлаар онцолжээ. Үүнд: компаниуд авлига, хахууль өгөхгүй байх (46.4%), шударга зарчмаар ажиллах (44.6%), хууль, хяналтын хэрэгжилтийг чангатгах (44.0%), Авлигатай тэмцэх газар мэдээлэх (33.8%) зэргийн онцолжээ.
- Энэ нөхцөл байдал нь хувийн хэвшлийн дотоод бодлого, ёс зүйн соёл, нийгмийн хариуцлагын тогтолцоо сул байгааг харуулж байна. Тиймээс бизнесийн салбар өөрийн түвшинд авлигатай тэмцэх бодлого, дотоод журам, сургалт, ил тод байдлын механизмыг нэвтрүүлэх шаардлагатай. Тухайлбал: авлигын эсрэг дотоод бодлого боловсруулж хэрэгжүүлэх, компанийн ёс зүйн дүрэм гарган мөрдүүлэх, ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулж, авлигын эрсдэлийг таних, мэдээлэх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор гэрээ, худалдан авалт, санхүүгийн зарцуулалтын мэдээллийг тодорхой түвшинд олон нийтэд нээлттэй болгох, салбарын түвшинд хамтын ажиллагаа

өрнүүлж, бизнесийн холбоодын хүрээнд авлигын эсрэг санаачилга хэрэгжүүлэх зэргийг дурдаж болно.

- Эдгээр алхмууд нь бизнесийн байгууллагуудын дотоод итгэлцлийг бэхжүүлэхийн зэрэгцээ нийт салбарын өрсөлдөх чадварыг сайжруулах, улмаар төрийн бодлоготой уялдан авлигыг бууруулахад чухал хувь нэмэр оруулах боломжтой.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

“Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал” судалгааг энэ удаад МУИС-ийн Нийгмийн судалгааны хүрээлэн дангаар хэрэгжүүлсэн болно. Үүнээс өмнө, 2018 оны судалгааг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, Австралийн Гадаад хэрэг, худалдааны яам, Канадын Гадаад хэргийн яамны санхүүжилтээр Азийн сан болон Сант Марал сан хамтран зохион байгуулж байв. Энэ удаагийн судалгаанд хэрэглэсэн асуумжийг хэл найруулга, агуулгын хувьд шинэчлэн боловсруулж, анхдагч өгөгдөл цуглуулсан нь онцлог юм. Судалгааны хүрээнд бизнесийн байгууллагын төрөл хэлбэрийн ангиллыг өргөтгөж, хувьсагчийн мэдээллийг баяжуулан, асуултыг өдөр тутмын амьдралын хэлэнд ойр, ойлгомжтой байдлаар найруулсан байна.

Судалгаанд тоон судалгааны бүтэцчилсэн асуумжийн аргыг (quantitative structured survey) ашигласан. Асуумжийг бөглүүлэхдээ нууцлалыг бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлж, өөрөө бөглөх болон ярилцлагаар бөглүүлэх хэлбэрийг хослуулсан. Хариултыг бүрэн нууцлах баталгааг олгож, судалгааны зорилгыг танилцуулсны дараа респондентүүдийг зөвхөн сайн дурын үндсэн дээр судалгаанд оролцуулсан. Уулзалт, ярилцлагыг зөвхөн компанийн гүйцэтгэх захирал эсвэл удирдах түвшний албан тушаалтантай хийсэн.

Судалгааны гол зорилго нь бизнес эрхлэгчдийн дунд авлигын тархалт, хэлбэр, түвшинг тэдний өөрийн үнэлгээнд тулгуурлан тодорхойлох, авлигын шалтгаан, гол салбар болон холбогдох байгууллагыг илрүүлэх, авлигын бизнесийн зардал болон шударга өрсөлдөөнд үзүүлэх нөлөөг үнэлэх, цаашид авлигатай тэмцэх бодлогын хэрэгцээ, бизнес эрхлэгчдийн санал, үзэл хандлагыг тодорхойлоход чиглэж байна.

Судалгааны эх олонлог нь Монгол Улсад албан ёсоор бүртгэгдсэн жижиг, дунд, том бизнесийн байгууллагын удирдлага, менежер, өмчлөгчид байсан. Түүвэр нь салбараар (барилга, худалдаа, үйлчилгээ, уул уурхай, хөдөө аж ахуй, санхүү гэх мэт) болон байршлаар (Улаанбаатар хотын аж ахуйн нэгжүүд) ангилсан санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон. Түүврийн хэмжээний хувьд Улаанбаатар хотын 350 бизнес эрхлэгчийг хамруулсан бөгөөд энэ нь 95%-ийн итгэлцлийн түвшин, $\pm 5\%$ -ийн алдааны хязгаартайгаар тооцоологдсон. Өмнөх судалгаануудын үеэр цуглуулсан мэдээлэлд үндэслэн нийслэлд байрладаг аж ахуйн нэгжүүдийн тогтмол шинэчлэгддэг жагсаалтыг ашигласан. Жишээлбэл, 2018 оны судалгаанд нийт 1860 аж ахуйн нэгжээс 330-ыг түүврийн аргаар сонгон оролцуулж байжээ. Томоохон аж ахуйн нэгжүүдийн тоо харьцангуй цөөн тул зарим нь

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

судалгаанд давхардан орсон байх боломжтой. Харин жижиг болон дунд хэмжээний аж ахуйн нэгжүүд санамсаргүй түүврийн аргаар сонгогдон хамрагдсан.

Энэ удаагийн судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2025 оны 6 дугаар сарын 24-ны өдөр эхлүүлэн 8 дугаар сарын 22-ны өдөр дуусгав.

Мэдээлэл цуглуулахад судалгаанд оролцогчид бие даан хариултыг ирүүлэх эсвэл ганцаарчилсан уулзалт, ярилцлагын аргыг ашигласан болно.

БҮЛЭГ 1. ТҮҮВРИЙН ТАНИЛЦУУЛГА

Дүүргийн түвшинд:

2012–2018 оны хооронд бизнес эрхлэгчдийн дүүргийн төлөөллийн харьцаа тогтвортой байсан бол 2025 онд тодорхой өөрчлөлт орсон. Энэ өөрчлөлтийг арга зүйн шинэчлэл, бизнесийн байршлын шилжилт болон түүвэр сонголтын өөрчлөлтөөр тайлбарлаж болно. Судалгааг нийслэл хотод хэрэгжүүлсэн нь бизнесийн орчны авлигын нөхцөл байдлын ерөнхий дүр зургийг хотын хэмжээнд гаргах боломжийг олгосон.

Өмнөх жилүүдэд дүүргүүдийн төлөөллийн харьцаа тогтвортой, нэг дүүргийн эзлэх хувь мэдэгдэхүйц хэлбэлзэлгүй байсан нь цаг хугацааны харьцуулалт хийх боломж олгож байв. Сүхбаатар, Баянгол, Сонгинохайрхан дүүргүүд хамгийн өндөр төлөөлөлтэй байсан нь эдгээр дүүрэгт бизнесийн үйл ажиллагаа төвлөрснийг илтгэнэ. Чингэлтэй дүүргийн төлөөлөл харьцангуй бага хэвээр байсан бөгөөд 2025 онд Налайх дүүргийг шинээр хамруулснаар түүвэрт өөрчлөлт орсон. Хан-Уул дүүргийн төлөөлөл огцом нэмэгдсэн бол Баянгол, Чингэлтэй дүүргүүдийн эзлэх хувь бага зэрэг буурсан байна (Зураг 1.1).

Салбарын түвшинд:

2025 оны судалгаанд зарим шинэ салбаруудыг (жишээлбэл мэдээллийн технологи болон бусад төрөл) оруулсан боловч тэдгээрийн төлөөлөл харьцангуй бага байна. Үйлчилгээний салбар өмнөх судалгаануудын адил статистикийн чиг хандлагын дагуу өндөр төлөөлөлтэй байсан бол худалдаа, үйлдвэрлэлийн салбар тогтвортой байв. Харин уул уурхай, хөдөө аж ахуйн салбарын төлөөлөл бага зэрэг буурсан байна. Мөн бизнес эрхлэгчдийн дөрөвний нэг нь нэгээс илүү чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг учир судалгаанд респондентийн гол үйл ажиллагааны чиглэлээр ангилж бүртгэсэн. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид зэрэгцэн үйлчилгээ, худалдааны салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулах, үйлдвэрлэгчид өөрсдийн бүтээгдэхүүнээ борлуулах зэрэг нь нийтлэг болжээ (Зураг 1.2).

Аж ахуйн нэгжийн хэмжээний түвшинд:

Түүвэрт жижиг компаниуд илүү өндөр хувьтай хамрагдсан бөгөөд дунд хэмжээний компаниудын эзлэх хувь жилээс жилд савлагаатай боловч тогтвортой хэвээр байна. Томоохон компаниудын нөлөө харьцангуй нэмэгдэж байгаа нь эдийн засгийн төвлөрөл гүнзгийрч буйг харуулна. Энэ өөрчлөлтөд мөнгөн дүнгээр хэмжих шалгуур, төгрөгийн ханш болон инфляцын нөлөөг тооцох шаардлагатай. Өмнөх ангиллыг (жижиг: 150 саяас доош, дунд: 150 сая–2 тэрбум, том: 2 тэрбум ба түүнээс дээш) шинэчилж, 2025 онд жижиг: 300 саяас доош, дунд:

300 сая–2.5 тэрбум, том: 2.5 тэрбум ба түүнээс дээш гэж өөрчилсөн. Энэ нь Монголын бизнесийн бүтэц жижиг компани давамгайлснаас томоохон компаниудын нөлөө нэмэгдэх, төвлөрөх хандлагад шилжиж буйг илтгэнэ (Зураг 1.3).

2012 онд жижиг компаниудын эзлэх хувь 45.5% байсан бол 2016 онд 50%-д хүрч оргилдоо гарсан ч дараа нь буурч, 2025 онд 40.5% болжээ. Дунд компаниуд 2012 онд 40.3% байсан ч 2014 онд 33.6%-д хүрч буурсан. 2015–2018 онд сэргэлт ажиглагдсан ч 2025 онд 37.6%-д хүрчээ. Том компаниуд 2012 онд 14.2% байсан бол 2025 онд 21.9%-д хүрсэн байна. Энэ нь эдийн засагт томоохон компаниудын нөлөө тогтмол өсөж буйг харуулна.

Аж ахуйн нэгжийн үүсгэн байгуулагдсан үеийн ангилал:

Компаниудыг гурван үеэр ангилсан (Зураг 1.4):

1. 2000 оноос өмнө байгуулагдсан: зах зээлд шилжилтийн үеийн тогтворгүй, хууль эрх зүйн сул орчин, системийн авлигын эхлэл тавигдсан үе.
2. 2001–2010 онд байгуулагдсан: эдийн засгийн өсөлт, уул уурхай, дэд бүтцийн хөрөнгө оруулалтын үе. Энэ үед тендер, лицензийн авлигын эрсдэл нэмэгдэж, дунд ба том компаниуд төрийн худалдан авалт, концессод идэвхтэй оролцож эхэлсэн.
3. 2011 оноос хойш байгуулагдсан: эдийн засгийн өндөр өсөлт, шинэ бизнесийн давлагаа, улс төрийн тогтворгүй байдлаас үүдэлтэй эрсдэлийн савлагаа, томоохон авлигын хэрэг, мега төслүүдийн эрсдэл нэмэгдсэн үе.

Энэ ангилал нь бизнесийн орчин дахь өөрчлөлт, авлигын эрсдэлийн хэлбэрийг илүү тодорхой харьцуулан шинжлэх боломжийг олгож байна.

Хүйсийн бүтэц:

Судалгаанд оролцсон байгууллагуудын ажилчдын хүйсийн харьцааг авч үзэхэд (Хүснэгт 1.1; Зураг 1.5, 1.6) эрэгтэй давамгай байгууллагууд (60–70% эрэгтэй) нийтлэг (≈30%) байсан бол эмэгтэй давамгай байгууллагууд (60–80% эмэгтэй) нийтдээ 35% орчим байжээ. Харин яг тэнцвэртэй буюу 50*50 харьцаатай байгууллага 10% орчим байсан нь харьцангуй ховор тохиолдол байв. Нийт байгууллагын маш багахан хувьд (≈2.6%) 100% эрэгтэй, 4.9%-д 100% эмэгтэй ажилчид бүрдүүлж байсан нь хүйсийн туйлшрал харьцангуй бага түвшинд байгааг харуулна.


Компанийн хэмжээ томрох тусам эрэгтэй ажилчдын эзлэх хувь өсч, хүйсийн харьцаа тэнцвэргүй болох хандлагатай байна. Жижиг компаниудад харьцангуй

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

олон янзын бүтэцтэй бол дунд компаниудад 60*40, 70*30, 50*50 харьцаа давамгайлж, том компаниудад эрэгтэй давамгайл илүү тод харагдсан.


Салбарын түвшинд хүйсийн харьцаа ялгаатай: хүнд үйлдвэр, уул уурхай, барилга зэрэг уламжлалт салбарууд эрэгтэй давамгайл хэвээр байхад худалдаа, үйлчилгээ, мэдээллийн технологийн салбаруудад эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэж, хүйсийн тэнцвэрт байдалд дөхөж байна. Жишээлбэл, худалдааны салбарт 60*40 (22.1%) болон 70*30 (19.5%) харьцаатай байгууллагууд зонхилж байгаа бол барилгын салбарт эрэгтэй давамгайлсан бүтэц давамгайлсан (жишээлбэл 90*10 – 16.7%), гэхдээ 50*50 харьцаатай байгууллагууд (23.3%) ч байжээ. Уул уурхайн салбарт эрэгтэй хүйс давамгайлж хамгийн өндөр (100% эрэгтэй – 28.6%), харин хөдөө аж ахуйн салбар харьцангуй олон янзын бүтэцтэй байлаа. Мэдээллийн технологийн салбарт эрэгтэй давамгайлалт өндөр (80*20 – 37.5%), гэхдээ эмэгтэйчүүдийн оролцоо чухал байр суурь эзэлж байна.

Зураг 1.1. Судалгаанд оролцогч аж ахуйн нэгжүүдийн хуваарилалт /газар зүйн байршлаар/




БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Зураг 1.2. Судалгаанд оролцогч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл




Зураг 1.3. Жилийн эргэлтийн хөрөнгийн хэмжээ



БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН


Зураг 1.4. Үүсгэн байгуулагдсан он



Хүснэгт 1.1. Байгууллагын ажилчдын хүйсийн харьцаа


Хүйс	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Эрэгтэй	100 %	90 %	80 %	70 %	60 %	50 %	40 %	30 %	20 %	10 %	0 %
Эмэгтэй	0 %	10 %	20 %	30 %	40 %	50 %	60 %	70 %	80 %	90 %	100 %
Байгууллагын	2.6 %	5.2 %	6.4 %	14.7 %	15.6 %	10.4 %	14.5 %	11.6 %	8.7 %	5.5 %	4.9 %

Зураг 1.5. Компанийн ажилчдын хүйсийн харьцаа



БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Зураг 1.6. Компанийн үйл ажиллагааны чиглэл, хүйсийн бүтэц



БҮЛЭГ 2. БИЗНЕСИЙН ОРЧИН

Дэлхийн банкны “Монголын эдийн засгийн тойм” болон бусад эх сурвалжийн мэдээллээс харахад Монгол Улсын эдийн засаг 2024 онд ойролцоогоор 5 хувиар өссөн байна. Энэ нь өмнөх жилийн өндөр өсөлтөөс саарсан дүн боловч уул уурхай, хөдөө аж ахуйн салбарын сэргэлтээр тодорхойлогдож байна. Инфляцын түвшин 6.8 хувьтай гарч, төв банкны зорилтот түвшинтэй ойролцоо хадгалагдсан боловч дотоодын эрэлт болон төсвийн зарлага өссөнөөр макро эдийн засгийн дарамт нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.


Сүүлийн үед төсвийн тэнцэлд онцгойлон анхаарсны үр дүнд улсын өрийн ДНБ-д эзлэх хэмжээ буурсан нь санхүүгийн тогтвортой байдлын эерэг шинж тэмдэг болсон. Харин 2025 онд эдийн засаг 6.3–6.5 хувийн өсөлттэй байх төлөвтэй ч инфляцын түвшин хоёр оронтой тоонд хүрч, 10 хувь орчим болох эрсдэл дагуулж байна.

Уул уурхай болон хөдөө аж ахуйн салбар нь өсөлтийн гол хөдөлгөгч хүчин хэвээр байгаа хэдий ч төсвийн алдагдал –1.1 хувьтай гарч, урсгал дансны алдагдал нэмэгдэх төлөвтэй байна. Тиймээс эдийн засгийн өсөлт нь тогтвортой байдлын сорилттой тулгарч, ялангуяа инфляц, төсвийн сахилга бат болон гадаад худалдааны тэнцлийн алдагдалтай уялдах хандлагатай байна. Иймд бодлогын түвшинд санхүүгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлийг бууруулах чиглэлд илүү онцгойлон анхаарах шаардлагатай байна.

Энэ удаагийн судалгаанд бизнесийн орчны ерөнхий нөхцөл байдлыг респондентоор үнэлүүлж, авлигын эрсдэлт хүчин зүйлсийг харьцуулан шинжилсэн юм. Үүнд юуны өмнө чанарын үзүүлэлт болгон бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал судалгааны оролцогчид бизнесийн орчинд сэтгэл ханамжийг үнэлүүлж, өмнөх онуудын өгөгдөлтэй харьцуулан шинжиллээ (Зураг 2.1.) Аж ахуй эрхлэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ бүхэлдээ 2025 онд сайнгүй байна.

Зураг 2.1. Бизнесийн орчны талаарх сэтгэл ханамж

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН




Хариултын үр дүнгээс харахад 2012–2018 оны хооронд бизнес эрхлэгчдийн олонх нь “бага зэрэг сэтгэл хангалуун” гэж үнэлж байсан бол 2025 онд энэ дундаж үнэлгээ эрс буурч, оронд нь “огт хангалуун бус” гэсэн сөрөг үнэлгээ огцом өссөн нь анхааруштай байна. Тухайлбал, “маш сэтгэл хангалуун” болон “харьцангуй сэтгэл хангалуун” гэсэн эерэг үнэлгээний нийлбэр 2012 онд 27.2 хувь байсан бол 2025 онд ердөө 18.9 хувь болж буурсан байна. Харин “огт хангалуун бус” гэсэн сөрөг үнэлгээ 2012 онд 17.6 хувь байсан бол 2025 онд 35.6 хувь болж, бараг хоёр дахин өсжээ. Өмнө нь давамгайлж байсан дундаж буюу төвийн үнэлгээ (“бага зэрэг сэтгэл хангалуун”) 2025 онд огцом буурсан нь бизнес эрхлэгчдийн дунд эергээс илүү эргэлзээтэй, сөрөг байр суурь давамгайлах болсон чиг хандлагыг харуулж байна. Өөрөөр хэлбэл, бизнесийн орчны талаарх эерэг үнэлгээ буурч, сөрөг үнэлгээ мэдэгдэхүйц өссөн нь 2025 оны онцлох өөрчлөлт бөгөөд бодлогын түвшинд бизнес эрхлэгчдийн итгэлийг сэргээх, бизнесийн орчныг тогтвортой, таатай болгох шаардлагатайг илтгэж байна.

Судалгаагаар “Маш сэтгэл хангалуун” гэсэн эерэг үзүүлэлт 2012–2018 онд тогтмол маш бага (0–2 хувь) байсан бол 2025 онд 4.0 хувь болж өмнөх жилүүдээс өндөр үзүүлэлт гарсан ч нийт дүнгээрээ буурсан байна. Харьцангуй сэтгэл хангалуун гэж хариулсан хүмүүс 2012 онд 24.8 хувь байсан бол 2013–2016 онд 12–20 хувь-ийн хооронд буурч, 2017–2018 онд түр зуур өссөн ч (17.3 хувь), 2025 онд 14.9 хувь болж буурсан нь эерэг үнэлгээний түвшин 10 гаруй жилийн хугацаанд нийтдээ буурсныг илтгэж байна. Бага зэрэг сэтгэл хангалуун гэсэн хариулт хамгийн өндөр хувийг эзэлж байсан бөгөөд 2012–2018 онд 50–63 хувь хооронд хэлбэлзэж байсан бол 2025 онд 40.2 хувь болж огцом буурсан нь бизнес эрхлэгчдийн “дундаж сэтгэл ханамж” мэдэгдэхүйц суларсныг илтгэнэ. Огт хангалуун бус гэсэн хариулт 2012–2018 онд 17–25 хувь-ийн хооронд хэлбэлзэж байсан бол 2025 онд 35.6 хувь болж эрс өссөн нь бизнесийн орчинд сөрөг үнэлгээ давамгайлах хандлага бий болсныг харуулж байна.

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Үүнийг мөн олон жилийн дундаж үзүүлэлтээр харьцуулан үзүүлээ.

Зураг 2.2. Бизнесийн орчны сэтгэл ханамжийн үнэлгээний дундаж. Он оноор харьцуулсан үзүүлэлт (Бизнесийн орчны үнэлгээний дундаж (маш сэтгэл хангалуун* +2, харьцангуй сэтгэл хангалуун* +1, бага зэрэг сэтгэл хангалуун бус* -1, огт сэтгэл хангалуун бус* -2))



Дээрх үр дүнгээс харахад 2012–2025 оны хооронд бизнесийн орчны сэтгэл ханамжийн дундаж тогтвортойгоор сөрөг чиг хандлагатай байсан бөгөөд түр зуурын сайжралтууд удаан хадгалагдаагүй байна. Энэ хугацаанд дундаж үнэлгээ ихэвчлэн -0.7 -аас -1.0 хооронд хэлбэлзэж, эерэг түвшинд хүрсэн тохиолдол ажиглагдсангүй. 2025 оны түвшин (-0.94) нь 2012 оныхоос дордсон, харин 2016 оны хамгийн доод цэгээс арай дээр байгаа ч нийт дүнгээрээ “хангалуун бус” байр суурь давамгайлсан хэвээр байна. Энэ нь бизнес эрхлэгчид Монголын бизнесийн орчныг тогтворгүй, таатай бус, сэтгэл ханамжгүй гэж үнэлсээр ирснийг харуулж байна. Иймээс бодлогын түвшинд бизнесийн итгэлийг сэргээх, эрх зүйн болон зах зээлийн орчны тогтвортой байдлыг хангах шаардлагатай байна.

Судалгааг анх хийсэн 2012 онд дундаж үнэлгээ -0.58 байсан нь бага зэрэг сөрөг чиглэлтэй байсныг харуулдаг. Харин 2013–2014 онд энэ үзүүлэлт тасралтгүй буурч, 2013.05 сард -0.76 болж, 2013.10 сар болон 2014.04 саруудад -0.8 -аас -0.95 хүртэл дордсон байна. Энэ үед бизнесийн орчны сэтгэл ханамжийн түвшин хамгийн доод цэгтээ хүрсэн гэж дүгнэж болно. 2014.09 сард түр зуурын сэргэлт ажиглагдаж (-0.73) хүрч үзүүлэлт сайжирсан ч 2015.09 сард дахин -0.91 болж суларсан нь богино хугацааны эерэг өөрчлөлт тогтворгүй байсныг харуулж байна. 2016.09 онд хамгийн муу түвшинд хүрч -1.0 гэсэн дүн гарсан нь судалгааны бүх хугацаанд бүртгэгдсэн хамгийн доод үзүүлэлт юм.

2017–2018 онд бага зэрэг сэргэлт гарч, 2017.09-д -0.83 болж сайжирсан боловч 2018.09 гэхэд -0.93 болж буурсан байна. Харин 2025.08-д -0.94 болж,

өмнөхөөс бага зэрэг муудсан үзүүлэлттэйгээр тогтжээ. Ерөнхий чиг хандлагаар нь авч үзвэл бизнесийн орчны талаарх дундаж үнэлгээ тогтмол сөрөг хэвээр хадгалагдаж, урт хугацаанд дордсон байна.

Бизнесийн орчны сэтгэл ханамжийг компанийн хэмжээгээр харьцуулан үзвэл (Зураг 2.3) дунд хэмжээтэй компаниуд хамгийн өндөр эерэг үнэлгээтэй байна. Тодруулбал, “маш хангалуун” болон “хангалуун” гэсэн эерэг үнэлгээ дунд компаниудад 21.8 хувьтай гарсан бол жижиг компаниудад 18.7 хувь, том компаниудад 13.4 хувьтай байсан. Харин хамгийн өндөр сөрөг үнэлгээ том компаниудад (81.3%) бүртгэгдсэн бол дунд компаниудын сөрөг үнэлгээ 73.6 хувьтай, жижиг компаниудын хувьд харьцангуй доогуур байжээ.


Жижиг компаниуд бизнесийн орчныг ихэвчлэн тааламжгүй гэж үзэж байгаа ч тэдний дунд эергээр үнэлсэн хэсэг тодорхой хэмжээнд байна. Дунд компаниуд хамгийн өндөр эерэг үнэлгээтэй бүлэг болж харагдаж байгаа бол том компаниуд хамгийн сөрөг байр суурьтай байна. Энэ нь томоохон компаниуд илүү өндөр хүлээлттэй, олон төрлийн зохицуулалтын дарамтад өртөх магадлал өндөртэй байгаагаар холбоотой байж болох юм.

Ерөнхийдөө компанийн хэмжээ томрох тусам бизнесийн орчны талаарх сэтгэл ханамж буурч, сөрөг үнэлгээ нэмэгдэж буй хандлага ажиглагдаж байна. Энэ нь бодлого боловсруулахдаа жижиг, дунд, том бизнесийн онцлог, тулгамдсан асуудлыг тэнцвэртэй харгалзан үзэж, нийтлэг бэрхшээлийг цогцоор нь шийдвэрлэх шаардлагатайг харуулж байна.

Бизнесийн орчны сэтгэл ханамжийн дундаж үнэлгээг компанийн хэмжээ (жижиг, дунд, том)-ийн ангилал болон 2012–2025 оны хоорондох өөрчлөлтөөр харьцуулан шинжилсэн болно (Зураг 2.4). 2012–2025 онд бизнесийн орчны сэтгэл ханамжийн дундаж бүх компанийн хэмжээнд тогтмол сөрөг байгаа бөгөөд жижиг компаниуд хамгийн их савлагаатай буюу 2018 онд хамгийн муу үнэлгээ (-1.07) гарсан бол дунд хэмжээний компаниуд эхэндээ харьцангуй хамгийн эерэг үнэлгээтэй (-0.41) байсан ч 2014 оноос тогтмол сөрөг болж, 2025 онд (-0.93) сөрөг хэвээр байна. Харин том хэмжээний компаниуд 2013 онд хамгийн доод түвшин (-1.04)-д хүрч, 2025 онд -0.96 болж үзүүлэлт буурчээ. Компанийн хэмжээ томрох тусам үнэлгээний зураас тогтмол сөрөг чиглэлтэй хэвээр байна. Дунд компаниудын хувьд эхэндээ бага зэрэг эерэг байсан ч сүүлийн арван жилд тогтмол буурсан нь бизнесийн орчны тогтворгүй байдал, эрх зүйн болон зах зээлийн дарамт бизнесийн бүх түвшинд нөлөөлж байгааг харуулж байж болох юм. Бүхэлдээ үнэлгээний дундаж утга сөрөг (-0.4-аас -1.07 хүртэл) байгаа нь нийт бизнес эрхлэгчдийн сэтгэл ханамж доогуур түвшинд тогтмол хадгалагдаж байгааг илтгэнэ.

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Зураг 2.3. Бизнесийн орчны сэтгэл ханамжийг компанийн хэмжээгээр харьцуулсан шинжилгээ



Зураг 2.4. Бизнесийн орчны сэтгэл ханамжийн дунджийг компанийн хэмжээ болон он оноор харьцуулсан.




Бизнесийн орчны сэтгэл ханамжийг компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, салбараар харьцуулж шинжлэхэд ерөнхий чиг хандлагаар, бизнесийн орчны үнэлгээ сөрөг байр суурь давамгайлж байгаа бөгөөд ялангуяа үйлчилгээ, үйлдвэрлэлийн салбарынхан хамгийн ихээр хангалуун бус хандлагатай байна (зураг 2.5). Харин худалдааны салбарынхан харьцангуй илүү эерэг байр суурьтай боловч бас тодорхой хэмжээний сөрөг байр суурь илэрхийлж буй нь бизнесийн орчны туйлшрал, тогтворгүй байдлыг илтгэж байна. Эерэг үнэлгээ (маш хангалуун + хангалуун), Худалдаа болон үйлчилгээний салбар бусдаас

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

илүү эерэг байр суурьтай боловч нийт дүнгээрээ өндөр биш байна. Сөрөг үнэлгээ буюу хангалуун биш, огт хангалуун биш үнэлгээнд үйлчилгээний салбар хамгийн их сөрөг (67 орчим хувь) байгаа бол удаад нь үйлдвэрлэл, худалдаа оржээ. Худалдаа, үйлчилгээний салбарт эерэг ба сөрөг үнэлгээ аль аль нь өндөр, өөрөөр хэлбэл хоёр тийшээ савлаж хариулсан бол үйлдвэрлэлийн салбар “хангалуун биш” болон “огт хангалуун биш” давамгайлж байгаа нь тогтмол сөрөг байр суурийг харуулж байна. Харин барилга угсралт, уул уурхай, ХАА, мэдээлэл технологи зэрэг нь бага оролцоотой, харьцангуй жигд үнэлгээтэй байна (зураг 2.5).


Зураг 2.5. Бизнесийн орчны сэтгэл ханамжийг компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, салбараар харьцуулсан шинжилгээ



Сэтгэл ханамжийн үнэлгээг хүйсээр харьцуулж үзэхэд ерөнхийдөө бүх ангилалд сөрөг үнэлгээ (76 хувь) давамгайлж, бизнесийн орчинд итгэл сул байгаа ч хүйсийн тэнцвэртэй бүтэцтэй байгууллагуудын үнэлгээ бусдаасаа илүү эерэг гарсан нь онцлох үр дүн байлаа (зураг 2.6). Эрэгтэй ажилтан давамгайлж байгууллагууд (100 хувь эрэгтэй) болон эмэгтэй давамгайлж байгууллагууд (80 хувь+ эмэгтэй) бизнесийн орчныг хамгийн сөргөөр үнэлсэн бол хүйсийн тэнцвэртэй байгууллагууд бизнесийн орчныг харьцангуй илүү эергээр үнэлж, “маш хангалуун” болон “хангалуун” гэсэн хариултууд илүү өндөр байна.


БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Зураг 2.6. Бизнесийн орчны сэтгэл ханамжийн үнэлгээг хүйсээр харьцуулав



Бизнес эрхлэх орчны үнэлгээнд компани, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбоотой сүүлийн 1 жилийн хөрөнгө оруулалтын байдлыг бид шинжилсэн (Зураг 2.7). Хөрөнгө оруулалтын хувьд эерэг өөрчлөлт харьцангуй бага (13.3 хувь) байгаа нь сүүлийн жилд хөрөнгө оруулалтын идэвх сул байсныг илтгэх бөгөөд харин сөрөг өөрчлөлт өндөр (24.6 хувь) байгаа нь бизнесийн орчны дарамт, тодорхойгүй байдал хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлснийг харуулж байна. Идэвхгүй хэсэг буюу “хэвээрээ” (30.1 хувь) болон “мэдэхгүй” (31.9 хувь) гэсэн хоёр бүлэг нийт 60 хувь гаруйг эзэлж байна. Энэ нь бизнесийн ихэнх хэсэг нь хөрөнгө оруулалтын хэмжээг өсгөөгүй, харин тогтворгүй байдлыг илэрхийлж буйг харуулна. Өөрөөр хэлбэл, Монголын компаниудын хөрөнгө оруулалтын байдалд өсөлтөөс илүү бууралт, тогтворгүй байдал давамгайлж байгаа нь эдийн засгийн тодорхойгүй байдал болон бизнесийн итгэл сул байгааг харуулж байгаа юм.

Зураг 2.7. Бизнес аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбоотой сүүлийн 1 жилийн хөрөнгө оруулалтын байдал



БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Энэхүү үзүүлэлтийн хүрээнд мөн компани, аж ахуйн нэгжийн ирэх жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг мөн шалгах асуултаар оруулсан (зураг 2.8). Уг үзүүлэлтийн хувьд эерэг төлөв давамгайлж байгаа нь бараг тал нь (47.2 хувь) хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаагаас харагдана. Бизнесүүдийн ирээдүйд өсөлтийн боломж, өөдрөг хандлага бий гэдгийг харуулж байж болох юм. Сөрөг төлөв (11.3 хувь) бага хувьтай байгаа ч тодорхой хэмжээний эрсдэл байгаа нь тодорхой. Нөгөө талаас тодорхойгүй байдал (21.2 хувь) өндөр байгаа нь бизнесийн орчны тогтворгүй байдал, зах зээлийн итгэлийн асуудал байгааг илэрхийлнэ. Ерөнхийдөө компаниудын хөрөнгө оруулалтын төлөвлөлт өсөлтийн чиглэл давамгайлсан ч тодорхой хэсэг нь болгоомжтой буюу бууруулах, эсвэл тодорхойгүй байдалтай байгаа нь бодлогын түвшинд бизнесийн орчныг тогтворжуулах шаардлага байгааг илтгэж байгаа юм.


Зураг 2.8. Бизнесийн байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой ирэх жилүүдийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт ба хүлээлт



Компани, аж ахуйн нэгжийн хэмжээ болон хөрөнгө оруулалтын харьцаагаар шинжилж үзэхэд (зураг 2.9) жижиг хэмжээтэй компаниуд илүүтэй хөрөнгө оруулалтын хувьд хамгийн сул, тодорхойгүй (44.2 хувь) дүнтэй байгаа бол дунд компаниудын хувьд хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлсэн (20.3 хувь) болон хадгалсан (35.2 хувь) хувь хамгийн өндөр, тодорхойгүй байдал хамгийн бага байгаа нь ажиглагдлаа. Энэ нь хөрөнгө оруулалтын хувьд хамгийн идэвхтэй, тогтвортой бүлэг болохыг харуулж байна. Харин томоохон компаниудын хувьд хөрөнгө оруулалтаа хадгалсан өндөр хувьтай ч тодорхойгүй байдал (29.7 хувь) өндөр хэвээр байна. Ерөнхийдөө, дунд түвшний компаниуд хөрөнгө оруулалтад илүү идэвхтэй, жижиг компаниудын тодорхойгүй байдал өндөр, том компаниудын тогтвортой байдал дундаж түвшинд байгаа нь бизнесийн орчны нөхцөл байдлыг компанийн хэмжээ хэрхэн өөрөөр мэдэрч байгааг харуулж байгаа юм.

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Зураг 2.9. Хөрөнгө оруулалтын байдлыг салбараар харьцуулан байдал



Зургаас үзэхэд жижиг компаниуд хөрөнгө оруулалтаа өсгөсөн нь 7.2 хувь буюу маш бага хувь нь хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлсэн. Хэвээрээ нь 23.9 хувь буюу дөрөвний нэг орчим нь хөрөнгө оруулалтаа өөрчлөлгүй хадгалсан бол багасгасан хувь 24.6 хувь буюу мөн ижил дөрөвний нэг орчим нь хөрөнгө оруулалтаа бууруулжээ. Жижиг компаниудад хөрөнгө оруулалтын идэвх сул, тодорхойгүй байдал маш өндөр байгаа нь харагдаж байна. Харин дунд хэмжээтэй компаниудын хувьд хөрөнгө оруулалт өссөн дүн 20.3 хувь жижиг компаниудаас даруй 3 дахин их хувь нь хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлсэн бол хэвээрээ байгаа нь 35.2 хувь буюу хөрөнгө оруулалтаа тогтвортой хадгалсан бүлэг хамгийн өндөр байхад багасгасан газар 25.8 хувь буюу жижиг, том компаниудтай ойролцоо түвшинд байна. Дунд компаниуд хөрөнгө оруулалтын хамгийн идэвхтэй, хамгийн тогтвортой бүлэг болж байна. Том хэмжээтэй компаниудын хувьд хөрөнгө оруулалтаа өсгөсөн газрууд 13.5 хувь буюу жижиг компаниудаас өндөр, дунд компаниудаас доогуур байлаа. Гэтэл өнгөрсөн жилүүдтэй ижил хэвээрээ байгаа нь 32.4 хувь байсан бол хөрөнгө оруулалтаа багасгасан нь 24.3 хувь буюу дунд компаниудаас бага зэрэг бага байна. Том компаниудын хөрөнгө оруулалтын төлөв дунд компаниас тогтворгүй, жижиг компаниас дээр байгаа нь үндэсний статистиктай дүйж байгаа юм. Компанийн хэмжээ байгууллагын хөрөнгө оруулалтын хэмжээ нь статистик учир холбогдол бүхий ялгаатай байлаа (Зураг 2.10).

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Зураг 2.10. Хөрөнгө оруулалт болон компанийн хэмжээ хоорондын хамаарлын статистик шинжилгээний χ^2 үнэлгээний дүн


Chi-Square Tests

	Value	df	Asymptotic Significance (2-sided)
Pearson Chi-Square	66.998 ^a	18	0.000
Likelihood Ratio	81.236	18	0.000
Linear-by-Linear Association	5.568	1	0.018
N of Valid Cases	343		

a. 15 cells (50.0 хувь) have expected count less than 5. The minimum expected count is .44.

Энэхүү хөрөнгө оруулалтыг салбараар харьцуулж үзэхэд (зураг 2.11.) хөрөнгө оруулалт нэмэгдсэн салбаруудад барилга угсралт (20 хувь), худалдаа (19.5 хувь), ХАА (14.3 хувь боловч бууралт давамгай), Мэдээлэл технологи (25 хувь) зэрэг салбарууд оржээ. Харин хөрөнгө оруулалт буурсан салбаруудад ХАА (71.4 хувь), Худалдаа (35.1 хувь), Мэдээлэл технологи (37.5 хувь) орсон бол хамгийн тогтвортой салбар нь барилга угсралт (43.3 хувь хэвээрээ) болон бусад үйл ажиллагаа эрхэлдэг салбарууд (48.7 хувь хэвээрээ) оржээ. Хамгийн тодорхойгүй салбар бол үйлчилгээ (51.3 хувь), уул уурхай (85.7 хувь) болж байна. Нийт дүнгээрээ 13.3 хувь өссөн, 30.1 хувь хэвээрээ, 24.6 хувь буурсан, 31.9 хувь мэдэхгүй байна. Энэ нь бизнесийн орчны тодорхойгүй байдал өндөр, харин салбар хоорондын ялгаа маш том байгааг харуулж байгаа бөгөөд статистик шинжилгээгээр χ^2 0.001 (Pearson Chi-Square) байлаа.

Зураг 2.11. Компанийн хөрөнгө оруулалт болон салбарын харьцааны байдал




БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

БҮЛЭГ 3. БИЗНЕСИЙН ОРЧНЫ СААД БЭРХШЭЭЛ

Бизнесийн орчны хамгийн том саад болж буй хүчин зүйлсийн хувьд өндөр татварын дарамт байсаар байна (зураг 3.1). Өмнөх судалгааны дүн 2018 онтой харьцуулахад 2025 онд татварын дарамт, хууль эрх зүйн тогтворгүй байдал бизнес эрхлэгчдийн хувьд хамгийн том саад хэвээр байна. Харин зээл, санхүүгийн хүртээмж, авлигын дарамт, зөвшөөрлийн төвөгтэй байдал тодорхой хэмжээгээр буурч, бизнесийн орчинд энэ тал дээр бага зэрэг сайжрал гарсан байна. Гэвч ажиллах хүчний хомсдол, хүний нөөцийн дутагдалтай байдал шинэ тулгамдсан асуудал болон өсөж байгаа нь манай эдийн засгийн нийтлэг сорилт болоод байгаа бөгөөд цаашид хөдөлмөрийн бодлого, боловсролын чанарт анхаарах шаардлагатайг харуулж байгаа юм.

Зураг 3.1. Бизнесийн орчны хамгийн том саад бэрхшээлийг 2018 болон 2025 оны нөхцөлөөр харьцуулан илэрхийлэх бадал



БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Графикаас харахад бизнесийн хамгийн гол саад бэрхшээл хэмээн үзэгдэж байсан татварын дарамт 2018 онд 66.9% байсан бол 2025 онд 55.5% болж буурсан байна. Гэсэн хэдий ч бизнес эрхлэгчдийн дийлэнх нь татварын дарамтыг хамгийн том саад гэж үзсээр байгаа нь анхаарал татаж байна. Энэ нь татварын бодлогын өөрчлөлт, хяналтын хатуу чанд байдал, бизнесийн ашгийн мөнгөн хэмжээ бага байгаатай холбоотой.

Ерөнхийдөө эдийн засагт татварын шинэчлэл (НӨАТ, ААНОАТ-ын хувь хэмжээний өөрчлөлт, татварын өрийн хяналт чангарах) нь бизнесийн зардлыг өсгөж байгаа юм. Эдийн засгийн хямрал, КОВИД-19-ийн дараах төсвийн нөхцөл хүндрэлтэй хэвээр байсан тул татварын дарамт буураагүй, харин 2025 онд бага зэрэг хөнгөрсөн нь зарим уян хатан зохицуулалт, татварын цахим системийн үр дүнтэй холбоотой байж болох юм. 2018 оноос хойш Монгол Улсын төсвийн алдагдал тогтвортой өндөр хэвээр байж, татварын ачааллыг нэмэгдүүлэх бодлогын хандлага байгаа юм.

Албан ёсны хураамж, шимтгэлийн хувьд 2018 онд 12.1% байсан бол 2025 онд 17.0% болж өссөн. Энэ нь бизнесийн зардалд нэмэлт дарамт үүсгэж байгааг илтгэнэ. Нөгөө талаас албан бус хураамж 2018 онд 16.7% байсан бол 2025 онд 6.7% болж огцом буурсан харагдах ба энэ нь авлигын эсрэг бодлого, ил тод байдлын сайжрал тодорхой ахицтай байгааг харуулж байж болох юм. Мөн нийт эдийн засгийн хувьд 2018 онд банкны салбарын активын чанар муу, зээлийн хүү дунджаар 18–20% байж, жижиг дунд бизнесүүдэд том саад болж байсан. 2020 оноос Монгол банк бодлогын хүүг бууруулж, зээлийн хүү 2025 он гэхэд 13–14% болж буурсан. “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”, ЖДҮ-ийн сангийн шинэчлэл, “Ирээдүйн өв сан”-гийн зарим хөрөнгө оруулалт бизнесийн санхүүжилтийн хүртээмжийг харьцангуй сайжруулсан. Иймээс зээлийн хүртээмж бизнесийн хамгийн том бэрхшээлээс хоёрдогч түвшинд шилжсэн байж болох юм.

Санхүү ба хөдөлмөрийн зах зээлийн хүндрэл нь бизнес эрхлэгчдийн гол асуудал болж байгаа бөгөөд банк, санхүүгийн байгууллагаас зээл авах боломж муу байсаар байгаа нь мөн л эдийн засгийн маань нийтлэг сорилт байсаар байна. 2018 онд 41.8% байсан бол 2025 онд 16.4% болж буурчээ. Энэ нь нийт эдийн засгийн зарим үйл ажиллагаатай байж болох юм. Тухайлбал, 2019 оноос эхлэн авлигатай тэмцэх байгууллагын ил тод байдал, олон улсын хамтын ажиллагаа (GRECO, UNCAC)-ын хүрээнд зарим ахиц гарсан. Төрийн үйлчилгээний цахимжилт (E-Mongolia зэрэг платформ) нь шууд харилцааг багасгаж, жижиг хэмжээний авлигад хязгаар тавьсан. Гэхдээ томоохон тендер, концессын түвшинд ил тод байдлын асуудал үлдсэн ч өдөр тутмын бизнес эрхлэгчдэд тулгардаг авлигын дарамт буурсан байж болох юм.

Хөдөлмөрийн зах зээл дээр ажиллах хүчний хомсдол 2018 онд 13% байсан бол 2025 онд 17.0% болж өссөн. Энэ нь хөдөлмөрийн зах зээл дээр мэргэшсэн боловсон хүчний дутагдал, ялангуяа залуусын гадаад руу чиглэсэн шилжилт

хөдөлгөөн, ажиллах хүчний ур чадварын зөрүүтэй холбоотой. Мөн ажиллах хүчний мэргэжлийн ур чадвар хангалтгүй байгаа бөгөөд 2018 онд 21.2 хувь байсан бол 2025 онд 9.2 хувь болж буурчээ. 2018 оноос хойш залуусын гадаад ажиллах хүчний урсгал нэмэгдэж, 2022–2025 онд Солонгос, Япон, Европ руу хөдөлмөрийн шилжих хөдөлгөөн эрс өссөн юм. Дотоодын боловсрол, мэргэжлийн сургалт хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нийцэхгүй хэвээр байгаа бөгөөд үүнээс шалтгаалж бизнесүүд мэргэшсэн боловсон хүчин дутмаг, ажиллах хүчний хомсдолд орж байна.

Зах зээлийн орчин ба хууль эрх зүйн нөхцөл байдал тогтворгүй байгаа нь бас нэг удаах асуудал бөгөөд уг үзүүлэлт 2018 онд 22.1% байсан бол 2025 онд 23.6% болж нэмэгджээ. Энэ нь хууль тогтоомжийн байнгын өөрчлөлт, тогтворгүй байдал бизнес эрхлэгчдийн итгэлд нөлөөлсөөр байгааг илтгэнэ. Өмнөх судалгааг хийсэн үеэс 2018–2025 оны хооронд Татварын багц хууль, Хөдөлмөрийн хууль, Компанийн хууль зэрэг олон удаагийн шинэчлэл хийгдсэн. Хууль тогтоомж тогтворгүй, байнга өөрчлөгдөх нь бизнес эрхлэгчдэд урт хугацааны төлөвлөлт хийхэд хүндрэл учруулдаг нь тодорхой. Төрийн бодлогын тогтворгүй байдал, улс төрийн мөчлөгийн нөлөө (сонгуулийн өмнөх ба дараах өөрчлөлт) нь энэ үзүүлэлт өсөхөд нөлөөлж байгаа юм.


Бизнес эрхлэгчид зөвшөөрөл, лиценз авах болон сунгах үйл явцад тулгардаг хүндрэл, бэрхшээлийг чухалчилсаар ирсэн боловч уг үзүүлэлт 2018 онд 24.8% байсан бол 2025 онд 17.0% болж буурчээ. Энэ нь төрийн үйлчилгээний цахимжилт ахиж, хүнд суртал тодорхой хэмжээнд буурсныг илтгэж байна.

Дээрх асуудлууд нь манай эдийн засгийн нийтлэг асуудал бөгөөд 2018–2025 онд Монголын эдийн засаг КОВИД-19, түүхий эдийн үнийн хэлбэлзэл, гадаад өрийн дарамт, инфляц, төгрөгийн ханшийн уналт зэрэг олон хүчин зүйлээс хамаарч тогтворгүй байгаа юм. Энэ нь бизнесийн орчинд татварын дарамт ба хууль эрх зүйн тогтворгүй байдал гол асуудал хэвээр үлдэхэд хүргэсэн гэж үзэж болно. Харин зээл, санхүүгийн хүртээмж болон авлигын дарамт буурсан нь бодлого, зах зээлийн зарим шинэчлэлийн үр дүнг харуулж байгаа бөгөөд цаашид хөдөлмөрийн зах зээлийн хомсдол, хууль эрх зүйн тогтворгүй байдал нь бизнесийн орчинд улам томоохон сорилт болох төлөвтэй байна.

Судалгаанд мөн бизнес эрхлэхэд хамгийн их саад бэрхшээл, дарамт учруулж байгаа төрийн байгууллагууд юу байгааг асууж, шинжилгээ хийсэн юм (зураг 3.2). 2018-аас 2025 онд авлигын болон гаалийн дарамт тодорхой хэмжээгээр буурсан бол татвар, мэргэжлийн хяналт, газрын харилцаа, орон нутгийн захиргаа бизнесийн хамгийн том бэрхшээл болж өсжээ. Энэ өөрчлөлт нь төрийн байгууллагын татварын хяналт, лиценз, зөвшөөрлийн процессын төвөгтэй байдал, мөн газрын бодлогын тогтворгүй байдал бизнесийн орчинд улам том сорилт болсныг харуулж байна.

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Зураг 3.2. Бизнес эрхлэхэд нь хамгийн их саад, дарамт болдог байгууллага



Графикаас үзэхэд татварын алба онцгой өндөр хувьтай байна. 2018 онд 24.5% байсан бол 2025 онд 59.1% болж огцом өссөн бөгөөд энэ нь бизнесийнхэнд татварын шалгалт, нарийн төвөгтэй журам, өндөр татварын дарамт хамгийн том асуудал болсоор байгааг харуулж байна. 2018 оноос 2025 он хүртэл татварын цахим системийг нэвтрүүлсэн ч хяналт, шалгалтын давтамж, торгууль нэмэгдсэн нь бизнесүүдийн хувьд шинэ дарамт болжээ.

Удаад нь салбарын мэргэжлийн хяналт 2018 онд 17.6% байсан бол 2025 онд 45.0% болж өссөн дүнгээр жагсжээ. Энэ нь стандарт, шаардлага, хяналтын давтамж нэмэгдэж, зарим тохиолдолд давхардсан хяналт, торгууль нь бизнесийн үйл ажиллагааг хүндрүүлж байгааг харуулна. Мөн бусад төрийн тусгай чиг үүргийн байгууллага тухайлбал, гааль 2018 онд 21.9% байсан бол 2025 онд 9.1% болж буурсан. Энэ нь гаалийн үйл ажиллагаа цахимжиж, тодорхой ил тод байдал бий болсон ч импорт, экспортын орчны тогтворгүй байдлаас үлдсэн хүндрэлүүд байсаар байна. ХАБЭА (Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй) болон холбогдох байгууллагууд 2018 онд 20.7% байсан бол 2025 онд 20.7%-ийн орчим хэвээр байна. Энэ нь ажиллах орчин, хөдөлмөрийн стандартын шаардлага хэвээр хүчтэй саад болж байгааг илтгэнэ. Нийслэл, орон нутгийн захиргааны хувьд 2018 онд 4.2% байсан бол 2025 онд 18.4% болж нэмэгдсэн нь бизнесийн зөвшөөрөл, лицензийн процесс удаашралтай, хүнд сурталтай хэвээр байгааг харуулж байна. Газар, кадастрын албаны хувьд 2018 онд 1.8% байсан бол 2025 онд 16.7% болж эрс өссөн дүн харагдана. Газрын асуудал, өмчлөлийн тодорхойгүй байдал, барилгын зөвшөөрөл, кадастрын бүртгэлийн удаашрал нь бизнесийн томоохон саад болж хувирчээ.

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Бүхэлдээ 2018 онд хамгийн их саад болж байсан байгууллагууд нь гааль (21.9%), ХАБЭА (20.7%), татварын алба (24.5%) байсан бол 2025 он гэхэд татварын алба (59.1%), салбарын мэргэжлийн хяналт (45.0%), нийслэл/орон нутгийн захиргаа (18.4%), газар кадастрын алба (16.7%) нь бизнес эрхлэгчдийн дарамтын гол эх үүсвэр болж байна.

Хүснэгт 3.1. Байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон бизнест хамгийн их саад бэрхшээл учруулдаг байгууллагын харьцуулсан хүснэгт

	САЛБАРЫН МЭРГЭЖ- ЛИЙН ХЯНАЛТ	ГАЗАР, КАДАСТ- РЫН АЛБА	ЦАГ- ДАА	ТАТВА- РЫН АЛБА	ГААЛЬ	ХАБЭА ХАРИУЦ- САН НЭГЖ БАЙГУУЛ- ЛАГА	НИЙС ЛЭЛ, ОРОН НУТГИ ЙН ЗАХИР ГАА	БУС АД	МЭДЭХ -ГҮЙ
ҮЙЛЧИЛГЭЭ	53.9%	14.8%	8.7%	57.4%	17.4%	34.8%	13.0%	1.7%	11.3%
ХУДАЛДАА	39.0%	13.0%	11.7%	62.3%	23.4%	14.3%	19.5%	2.6%	7.8%
ҮЙЛДВЭР- ЛЭЛ	39.0%	15.3%	10.2%	57.6%	22.0%	6.8%	23.7%	6.8%	16.9%
БАРИЛГА УГСРАЛТ	40.0%	43.3%	3.3%	66.7%	20.0%	16.7%	20.0%	0.0%	13.3%
УУЛ УУРХАЙ	71.4%	28.6%	0.0%	71.4%	14.3%	71.4%	0.0%	0.0%	0.0%
ХАА	42.9%	42.9%	14.3%	28.6%	28.6%	0.0%	42.9%	0.0%	0.0%
ЭРЧИМ ХҮЧ	0.0%	0.0%	50.0%	50.0%	100.0%	0.0%	50.0%	0.0%	0.0%
ДЭД БҮТЭЦ, ЗАМ	50.0%	0.0%	0.0%	50.0%	50.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ , ХАРИЛЦАА	25.0%	0.0%	0.0%	37.5%	25.0%	0.0%	50.0%	0.0%	12.5%
БУСАД	45.0%	10.0%	5.0%	62.5%	27.5%	17.5%	15.0%	5.0%	5.0%

Дээрх үр дүнгээс харахад бүх салбарын нийтлэг асуудал нь Татварын алба бөгөөд бүх салбарт 50–70 хувийн түвшинд хамгийн том саад болж байна. Салбарын онцлогоос хамааран нэмж хамгийн их саад бэрхшээл дарамж учруулдаг байгууллагуудыг харвал:

- Үйлчилгээ салбарт: Мэргэжлийн хяналт
- Худалдаа, үйлдвэрлэлийн салбарт: Гааль, орон нутгийн захиргаа
- Барилгын салбарт: Газар, кадастрын алба
- Уул уурхайн салбарт: ХАБЭА, мэргэжлийн хяналт
- ХАА-н салбарт: Газрын харилцаа, орон нутгийн захиргааны байгууллагууд ажээ.


Салбар бүр өөрийн онцлог бэрхшээлтэй ч нийтлэгээр төрийн татварын хяналт, зөвшөөрөл олголтын төвөгтэй байдал, мэргэжлийн хяналтын давхар шалгалт нь бизнесийн хөгжлийг хамгийн их хязгаарлаж байна.

БҮЛЭГ 4. АЛДАГДАЛ БУЮУ ҮР АШИГГҮЙ ЗАРЦУУЛАЛТ

Авлига бизнесийн орчинд нүүрлэх нь эргээд улс орны эдийн засгийн амьдралд ихээхэн сөрөг үр нөлөөг бий болгодог. Юуны өмнө, бизнес эрхлэгчдийн хувьд авлига бол албан бус зардал бөгөөд эдийн засгийн жам ёсны эрх чөлөөг зүй бусаар хязгаарлаж, зохиомол хязгаарлалтын төлөө төлбөр төлөхийг шаардаж буй зүйл юм. Түүний улмаас бизнес алдагдалд орж, үр ашиггүй зарцуулалт хийдэг ба бизнесменүүдийн хувьд алдагдсан боломжуудыг үүсгэж байна. Энэ нь нэг талаас, бизнесменүүд өөрсдийн ажилд зарцуулах ёстой хэдий хэмжээний хугацааг бизнесийн буюу үйлдвэрлэлийн бус ажилд зарцуулж буйгаар, нөгөө талаас, компаниуд өөрсдийн хэд хэмжээний нөөц хөрөнгийг үүнд зориулж буйгаар илэрхийлдэг. Энэ судалгааны хүрээнд энэ талаарх бизнес эрхлэгчдийн төсөөллийг харуулж байна.

Ерөнхийдөө График 4.1-т сүүлийн арван жилийн хугацаанд, бизнес эрхлэгчдийн бус ажилд зарцуулах цаг хугацаа тодорхой хэмжээнд буурсан дүр зураг харагдана. Бизнес эрхлэхтэй холбоотой үйлдвэрлэлийн бус асуудлуудыг шийдвэрлэхэд бизнесийн цагийг огт зарцуулаагүй гэсэн хариулт сүүлийн арван жилд 1.4 хувиар, 2018 оны үр дүнтэй харьцуулахад 1.8 хувиар буужээ. Гэвч, 2012 оны үр дүнтэй харьцуулахад өссөн байгаа нь анхаарал татаж байна.

Зураг 4.1. Бизнес эрхлэлттэй холбоотой үйлдвэрлэлийн бус асуудлыг шийдвэрлэхэд зарцуулдаг ажлын цаг




БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Бизнесменүүд дээрх төрлийн ажилд цагаа зарцуулж буй бүлгүүдийн хувьд өөрчлөлтүүд ялгаатай боловч, бас зөрчилтэй байдал харагдаж байна. Тухайлбал, өөрсдийн бизнесийн цагийн 25 хүртэлх хувийг зарцуулж буй бизнесменүүд дээрх хугацаанд эцсийн дүндээ 4-5 орчим хувь буурсан байна. Харин энэ бүлгийн эзлэх хэмжээ 2018 онд 40 хувь байсныг тооцвол өнөөдрийн байдлаар 10 хувиар буурчээ. Харин, ажлын цагийнхаа 25-50 хувийг зарцуулдаг гэж хариулсан бүлгийн хувь эргэж ямар нэгэн өсөлтгүй тууштай буурсаар, 2012 онд 27 хувь байснаас 2025 онд 14.6 хувь болж буурсан нь бизнесийн орчинд төрийн үйлчилгээтэй холбоотой хүнд суртал, чирэгдэл бага зэрэг буурах өөрчлөлтийг тусгаж байж болно. Түүнчлэн, хамгийн их хохиролтой гэж болох бизнес хийх цаг хугацааныхаа 50-аас их хувь зарцуулдаг бүлгийн хувь буурсан бөгөөд 2012 онд 12.1 хувиас 2025 онд 8 хувь болсон байна. 2025 оны судалгааны хүрээнд мэдэхгүй хэмээсэн хариултын хувь хэмжээ өндөр байгааг анхаарах хэрэгтэй.

График 4.2-т, 2015 оны 9-р сар болон 2025 оны 9-р сард бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэлийн бус ажил дахь цаг зарцуулалтын төсөөлөл өөрчлөгдсөн байна. 2015 онд 25 хүртэл хувийг зарцуулдаг бүлгийн хувь 33.9 хувь байсан, 2025 онд энэ хувь 30 хувь болж, 25-50 хүртэл хувийг зарцуулдаг бүлгийн хувь 2015 онд 23.3 хувиас 2025 онд 14.6 хувь, 50-иас их хувийг зарцуулдаг бүлгийн хувь 2015 онд 14.5 хувь байсан бол 2025 онд 8% хувь болж тус тус буурчээ. Мэдэхгүй гэсэн хариулт 2025 онд 34 хувьтай болж хамгийн өндөр хувийг эзэлж, бизнес эрхлэгчдийн хувьд тодорхой санахгүй, эсвэл хариулахаас татгалзах хэмжээ нэмэгдсэн байна.

Зураг 4.2. Бизнес эрхлэлттэй холбоотой үйлдвэрлэлийн бус асуудлыг шийдвэрлэхэд зарцуулдаг ажлын хэдэн хувийг зарцуулдаг вэ?



Хүснэгт 4.1-д буй харьцуулалтаас харахад, эргэлтийн хөрөнгөтэй хэмжээ бага байх тусам дээрх ажилд бизнесийн ажлын цагаас огт зарцуулдаггүй гэсэн

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

хариулт илүү хувьтай байгаа юм. Мөн, ажлын цагийн 25 хүртэл хувийг зарцуулах байдал нь байгууллагуудын хувьд эргэлтийн хөрөнгөнөөс үл хамааран харьцангуй жигд байдалтай байна. Харин, 2,500,000,000-аас дээш төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй байгууллагуудын ажлын цагийн 50-иас илүү хувийг үйлдвэрлэлийн бус асуудлыг шийдэхэд зарцуулдаг хувь хэмжээ бусад бүлгүүдээс анзаарагдахуйц нэмэгдэж байна. Ерөнхийдөө, эргэлтийн хөрөнгийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр цаг хугацааны алдагдал гаргах хандлага нэмэгдэж байна.

Хүснэгт 4.1. Бизнес эрхлэлттэй холбоотой (үйлдвэрлэлийн бус асуудал шийдэх) ажлын хэдэн хувийг зарцуулдаг вэ?

	Опт зарцуулдаг- гүй	25 хувь хүртэл	25-50 хувь	50 -иас их хувь	Мэдэхгүй	Нийт
300,000,000 төгрөгөөс бага	17.30%	18.70%	11.50%	7.90%	44.60%	100.00%
300,000,000- 1,000,000,001	17.10%	41.50%	15.90%	3.70%	22.00%	100.00%
1,000,000,000 - 2,500,000,001	8.50%	36.20%	23.40%	4.30%	27.70%	100.00%
2,500,000,000- 5,000,000,001	9.70%	41.90%	6.50%	19.40%	22.60%	100.00%
5,000,000,000 төгрөгөөс дээш	4.50%	34.10%	11.40%	13.60%	36.40%	100.00%

Бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэлийн бус асуудлуудыг шийдвэрлэхэд зарцуулж буй ажлын цагийн хувь хэмжээнд тэдний салбарын байдлаас хамаарсан зарим нэг ялгаа анзаарагдаж байна. Тухайлбал, худалдааны салбарынхан ажлын цагийнхаа 25 хүртэлх болон 25-50 хүртэлх хувийг зарцуулдаг хувь хэмжээ харьцангуй их байхад, барилга угсралтын салбарынхан 25 хүртэлх хувийг зарцуулах нь илүү өндөр хувьтай байна.

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Хүснэгт 4.2. Бизнес эрхлэлттэй холбоотой үйлдвэрлэлийн бус асуудлыг шийдвэрлэхэд ажлын хэдэн хувийг зарцуулдаг вэ?

	Огт зарцуулдаг- гүй	25 хувь хүртэл	25-50 хувь	50 -иас их хувь	Мэдэхгүй	
Үйлчилгээ	16.40%	22.40%	12.10%	7.80%	41.40%	100.00%
Худалдаа	22.80%	40.50%	29.10%	7.60%	0.00%	100.00%
Үйлдвэрлэл	3.40%	16.90%	10.20%	5.10%	64.40%	100.00%
Барилга угсралт	6.70%	40.00%	13.30%	13.30%	26.70%	100.00%
Уул уурхай	14.30%	0.00%	0.00%	14.30%	71.40%	100.00%
ХАА	14.30%	14.30%	42.90%	0.00%	28.60%	100.00%
Эрчим хүч	0.00%	50.00%	0.00%	0.00%	50.00%	100.00%
Дэд бүтэц, зам	0.00%	50.00%	0.00%	0.00%	50.00%	100.00%
Мэдээлэл технологии, харилцаа Бусад	25.00%	50.00%	0.00%	12.50%	12.50%	100.00%
	5.00%	45.00%	2.50%	10.00%	37.50%	100.00%


Бүлгийн эхэнд дурдсанчлан, авлигаас үүдэлтэй бизнесийн алдагдал, үр ашиггүй зарцуулалтын хоёр дахь чиглэл бол бизнесменүүд үйлдвэрлэлийн бус асуудлууд шийдвэрлэх, төрөөс бизнес эрхлэхтэй холбоотой үйлчилгээ авахын тулд байгууллагын нөөц хөрөнгөнөөс тодорхой хувийг зарцуулах явдал юм. График 4.3-т буй үр дүн, сүүлийн арав гаруй жилийн хугацаанд бизнес эрхлэгчид төрөөс үйлчилгээ авахын тулд байгууллагын хөрөнгө нөөцийг 25 хүртэлх хувьтай тэнцэх өртөг зардлыг төлөх нь нийтлэг буурсан дүр зургийг үзүүлж байна. Харин, 25 хувиас дээш буюу мэдэгдэхүйц өртөг зардлыг төлөх хувь нь дорвитой өөрчлөгдсөн зүйл үгүй юм.

2012 онд дээрх үйл ажиллагаанд байгууллагын хөрөнгөний 10 хүртэлх хувийг зарцуулдаг бүлгийн хэмжээ 36.4 хувь байсан бол 2025 онд 27.4 хувь болж, 10-25 хувийг зарцуулдаг бүлгийн хэмжээ 22.1 хувиас 13.1 хувь болж тус тус буурсан байна. Харин энэ удаагийн судалгааны хүрээнд уг асуудалд мэдэхгүй эсвэл хариулахаас татгалзсан хувь өмнөх онуудтай харьцуулахад харьцангуй өндөр хувьтай байна. 2012 онд бизнес эрхлэгчид төрийн үйлчилгээ хөрөнгө нөөц зарцуулахгүй байх нь 9.7 хувь байсан бол энэ үзүүлэлт 2015 онд огцом өсөж 24.2 хувьд хүрсэн ч 2018 онд 20 хувь болжээ. Хэдийгээр, 2025 онд энэ үзүүлэлт 16.3 хувь болж буурсан ч, арав гаруй жилийн өмнөхтэй харьцуулахад байгууллагуудын бизнес эрхлэхтэй холбоотой үйлчилгээнээс хүлээх өртгийн дарамт харьцангуй буурсан байна. Сүүлийн арван жилд (2012–2025) бизнес

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

эрхлэгчид төрөөс үйлчилгээ авахдаа зарцуулдаг нөөцийн дарамт 2015 онд хамгийн сайн буурч бизнесийн орчны төсөөлөл эерэг байжээ.

Зураг 4.3. Бизнес эрхлэлттэй холбоотой (үйлдвэрлэлийн бус асуудал шийдэх) төрөөс үйлчилгээ авахад зарцуулдаг байгууллагын хөрөнгө нөөцийн хувь



Бизнес эрхлэгчдийн төрөөс үйлчилгээ авахдаа зарцуулах өртөг зардал байгууллагын үйл ажиллагааны чиглэлээс хамааран онцлон үзэх ялгаа байхгүй байна.

Хүснэгт 4.3. Бизнес эрхлэлттэй холбоотой (үйлдвэрлэлийн бус асуудал шийдэх) төрөөс үйлчилгээ авахад байгууллагын хөрөнгө нөөцийн хэдэн хувийг зарцуулдаг вэ

	Огт үгүй	10 хүртэлх хувь	10-25 хувь	25-иас их хувь	Мэдэхгүй
Үйлчилгээ	18	27	18	7	46
	15.5%	23.3%	15.5%	6.0%	39.7%
Худалдаа	19	28	15	4	13
	24.1%	35.4%	19.0%	5.1%	16.5%
Үйлдвэрлэл	6	9	4	8	32
	10.2%	15.3%	6.8%	13.6%	54.2%
Барилга угсралт	4	15	1	2	8
	13.3%	50.0%	3.3%	6.7%	26.7%
Уул уурхай	0	2	1	1	3
	0.0%	28.6%	14.3%	14.3%	42.9%
ХАА	1	2	1	0	3
	14.3%	28.6%	14.3%	0.0%	42.9%
Эрчим хүч	0	2	0	0	0
	0.0%	100.0%	0.0%	0.0%	0.0%
Дэд бүтэц, зам	1	0	0	0	1
	50.0%	0.0%	0.0%	0.0%	50.0%
		2	0	3	1

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Мэдээлэл технологии, харилцаа	25.0%	0.0%	37.5%	12.5%
Бусад	6	11	3	5
	15.0%	27.5%	7.5%	12.5%

Бизнес эрхлэгчдийн төрөөс үйлчилгээ авахдаа зарцуулах өртөг зардал байгууллагын эргэлтийн хөрөнгийн хэмжээнээс хамааран ялгаатай байна. 300 саяас нэг тэрбум төгрөгийн хөрөнгөтэй дунд хэмжээний байгууллагуудын хувьд 10 хувиас доош зарцуулдаг нь хамгийн өндөр (36.6 хувь) байгаа нь бусад бүлгээс ялгарна. Харин 2.5–5 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй байгууллагуудын дунд 25 хувиас дээш зарцуулж буй нь 9.7 хувь хүрч, бусдаас хамгийн өндөр хувьтай байна. 5 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй томоохон байгууллагуудын дийлэнх нь (47.7 хувь) бага буюу 10 хувиас доош зарцуулдаг ч зарим нь маш өндөр буюу 25 хувиас дээш эрс тэс зарцуулж буйгаараа онцлог ялгаа болж байна. Харин, хөрөнгийн эргэлтийн хэмжээ багатай буюу 300 сая төгрөгөөс доош байгууллагуудын бараг тал нь (44.6 хувь) төрийн үйлчилгээ авахад хэдий хэр зарцуулдаг мэдэхгүй гэж хариулсан байна.

Хүснэгт 4.4. Бизнес эрхлэлттэй холбоотой (үйлдвэрлэлийн бус асуудал шийдэх) төрөөс үйлчилгээ авахад байгууллагын хөрөнгө нөөцийн хэдэн хувийг зарцуулдаг вэ?


	Огт үгүй	10 хүртэлх хувь	10-25 хувь	25-иас их хувь	Мэдэх- гүй	Нийт
300,000,000 төгрөгөөс бага	27	22	19	9	62	139
	19.4%	15.8%	13.7%	6.5%	44.6%	100.0%
300,000,000- 1,000,000,000	16	30	10	4	22	82
	19.5%	36.6%	12.2%	4.9%	26.8%	100.0%
1,000,000,000 - 2,500,000,000	5	16	8	3	15	47
	10.6%	34.0%	17.0%	6.4%	31.9%	100.0%
2,500,000,000- 5,000,000,000	6	5	6	3	11	31
	19.4%	16.1%	19.4%	9.7%	35.5%	100.0%
5,000,000,000 төгрөгөөс дээш	3	21	3	6	11	44
	6.8%	47.7%	6.8%	13.6%	25.0%	100.0%

Графикаас харахад, 2018 оны 9-р сараас 2025 оны 9-р сар хүртэл төсвөөс үйлчилгээг авахад зарцуулсан хувь мэдэгдэхүйц өөрчлөгдсөн байна. "Мэдэхгүй" хариулт 2025 онд 35.1% болж, 2018 оны 30.6%-аас өссөн нь бизнес эрхлэгчдийн хариулт тодорхойгүй байдал нэмэгдсэн гэдгийг илтгэнэ, харин "Огт зарцуулдаггүй" бүлгийн хувь 2018 онд 24.2% байсан бол 2025 онд 16.3% болж буурсан нь зарцуулалтыг бууруулах хандлагыг харуулж байна. Мөн "25-аас их хувь зарцуулдаг" бүлгийн хувь 2018 онд 8.1% байсан бол 2025 онд 18.2% болж

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

өссөн нь бизнес эрхлэгчдийн хувьд төрөөс авсан үйлчилгээнд зарцуулсан хувь нэмэгдсэн, ил тод байдал болон хариуцлагатай шийдвэр гаргалт сайжирсан болохыг илтгэнэ.

Зураг 4.4. Бизнес эрхлэлттэй холбоотой (үйлдвэрлэлийн бус асуудал шийдэх) төрөөс үйлчилгээ авахад зарцуулдаг байгууллагын хөрөнгө нөөцийн хувь хэмжээ




БҮЛЭГ 5. ТӨРИЙН АЛБАН ДАХЬ АВЛИГА

Сүүлийн таван жилд буюу тухайлбал, 2019 онд Монгол Улс “Транспэрэнси Интернэйшнл” байгууллагаас зохион байгуулдаг “Авлигын төсөөллийн индекс (CPI)”-ээр 35 оноотойгоор 180 орны дунд 106 дугаарт, 2020 онд мөн 35 оноо, 111 дүгээрт, 2021 онд 35 оноо, 110 дугаарт, 2022 онд 33 оноо, 116 дугаарт, 2023 онд 33 оноо, 121 дүгээрт тус тус эрэмбэлэгдсэн байна. Харин, 2024 онд Монгол Улсын авлигын индексийн оноо 33 хэвээр үлдэж, харин байршил нь 114 дүгээрт буюу өмнөх жилийн 121 дүгээр байраас 7 байр ахисан байна

График 5.1-ээс харахад, төрийн албан дахь авлигын нөхцөл байдал сүүлийн 10 жилийн хугацаанд тодорхой өөрчлөгдсөн байна. Юуны өмнө, бизнес эрхлэгчдийн төсөөллөөс харахад, төрийн албан дахь авлигын нөхцөл байдалд сүүлийн арав гаруй жилийн хугацаанд эерэг өөрчлөлт гарчээ. Төрийн албанд авлига "маш их" байна гэсэн хариултын хувь хэмжээ 2025 оных өмнөх гурван оныхтой харьцуулахад ихдээ бараг тал хувиар, багадаа 20 хувиар буурчээ. Арван жилийн өмнө энэ үзүүлэлт хамгийн өндөр байсан ба 2018 онд бараг 50 хувь байсан бол 2025 онд 26 орчим хувь болж буурсан юм. Түүнчлэн, энэ салбарт авлига "тодорхой хэмжээнд" байгаа гэх хариулт ч өмнөх онуудаас хамгийн багадаа 5 хувиар буурсан, ихдээ 11 хувиар тус тус буурсан юм.

Төрийн албанд авлига "бага зэрэг" гэсэн хариулт 2012 оноос 2018 он хүртэл төдийлөн өөрчлөлтгүй явсан бол 2025 онд 5 хувиар өссөн бол "байхгүй" гэх хариулт өмнөх гурван оныхтой харьцуулахад огцом өсөж 11.5 хувьд хүрсэн нь анхаармаар үр дүн болжээ. Эцэст нь, 2012 онд "Мэдэхгүй" гэсэн хариултын хувь 7.3% байсан бол 2025 онд энэ хувь 20.2% болж өссөн нь төрийн албанд авлига хэр их байгаа талаар тодорхойгүй байдал нэмэгдсэнийг илтгэж байна.


Зураг 5.1. Төрийн албаны авлигын хэмжээг үнэлэх байдал



БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Сүүлийн арван жилийн хугацаанд төрийн албан дахь авлигын нөхцөл байдал мэдэгдэхүйц өөрчлөгдсөн байгааг график 5.2-оос харж байна. Төрийн албанд "маш их" авлига байна гэж үзсэн хариулт 49.7 хувиас 26.3 хувь болж буурсан нь авлига хэмээх үзэгдлийн цар хүрээ хумигдаж байна гэж үзэх болсныг харуулж байна. Бизнес эрхлэгчдийн зүгээс авлигыг тийм их ноцтой хэмжээнд гэх төсөөлөл буурсан ч, "нэлээд хэмжээнд" авлига байгаа гэсэн хариулт 33.9 хувиас 28.8 хувь болж өмнөхтэй харьцуулахад тодорхой хэмжээнд буурсан нь авлига гэгч үзэгдэл өнөө хэр нь бугшиж хадгалагдсаар байгааг илтгэнэ. Цаашилбал, үүнтэй холбоотой дараагийн төсөөлөл бол төрийн албанд бага зэрэг авлига байгаа гэж үзэх нь 9.4 хувь байсан бол 13 хувь болж өссөн байна. Харин "мэдэхгүй" гэсэн хариулттай бүлгийн хувь 2018 оноос 2025 он хүртэл 6.7 хувиас 20.2 хувь болж өссөн нь өмнө дурдсанчлан олон нийт төрийн албан дахь авлигын талаарх төсөөлөл тодорхойгүй байгааг харуулж байна.

Зураг 5.2. Таны бодлоор төрийн албанд авлига хэр их байна вэ?



Хүснэгт 5.1-ээс харахад, орлогын хэмжээ нэмэгдэх тусам төрийн албанд "маш их" авлига байна гэж үзсэн хариултын хувь нэмэгдэж байгаа нь анхаарал татаж байна. 1,000,000,000 төгрөгөөс дээш хөрөнгийн эргэлттэй бүлгийн хувьд авлига "нэлээд байдаг" гэсэн хариулт эрс нэмэгдэж, 40 хувиас дээш гарч, хамгийн их хөрөнгө эргэдэг бүлэгт 50 хувьд хүрч байгаа юм. Харин авлига "маш их" гэж хариулах хувь хэмжээ хөрөнгө эргэлтийн ялгаатай бүлгүүдэд жигдхэн байдалтай, дунджаар бүх бүлгүүдийн дөрвөн бизнес эрхлэгч тутмын нэг нь ийнхүү төсөөлж байна.

Хүснэгт 5.1. Таны бодлоор төрийн албанд авлига хэр их байна вэ?

		Маш их	Нэлээд	Бага зэрэг	Байхгүй	Мэдэхгүй
300,000,000 төгрөг-с бага		39	25	16	24	33
		28.5%	18.2%	11.7%	17.5%	24.1%
300,000,000 төгрөг-с - 1,000,000,000		22	19	15	7	19
		26.8%	23.2%	18.3%	8.5%	23.2%

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

1,000,000,000 төгрөг-с - 2,500,000,000	10 21.3%	19 40.4%	6 12.8%	5 10.6%	7 14.9%
2,500,000,000 төгрөг- 5,000,000,000	8 25.8%	13 41.9%	3 9.7%	1 3.2%	6 19.4%
5,000,000,000 төгрөгөөс дээш	11 25.0%	22 50.0%	4 9.1%	3 6.8%	4 9.1%

Хүснэгт 5.2-т байгаа үр дүнгээс харахад барилга, уул уурхайн салбарынхан төрийн албыг илүү их (70 орчим хувь) авлигатай гэж үзэх хандлагатай байхад бусад салбарууд нь 50 орчим хувь нь авлига ихтэй гэж үзэж байна.


Хүснэгт 5.2. Таны бодлоор төрийн албанд авлига хэр их байна вэ?

	Маш их	Нэлээд	Бага зэрэг	Байхгүй	Мэдэхгүй
Үйлчилгээ	36 31.3%	21 18.3%	11 9.6%	18 15.7%	28 24.3%
Худалдаа	17 21.8%	25 32.1%	11 14.1%	10 12.8%	15 19.2%
Үйлдвэрлэл	16 27.1%	14 23.7%	12 20.3%	5 8.5%	12 20.3%
Барилга угсралт	6 20.0%	17 56.7%	2 6.7%	2 6.7%	3 10.0%
Уул уурхай	4 57.1%	1 14.3%	1 14.3%	0 0.0%	1 14.3%
ХАА	1 14.3%	1 14.3%	2 28.6%	0 0.0%	3 42.9%
Эрчим хүч	0 0.0%	2 100.0%	0 0.0%	0 0.0%	0 0.0%
Дэд бүтэц, зам	0 0.0%	1 50.0%	0 0.0%	0 0.0%	1 50.0%
Мэдээлэл технологи, харилцаа	1 12.5%	3 37.5%	3 37.5%	0 0.0%	1 12.5%
Бусад	11 28.2%	15 38.5%	2 5.1%	5 12.8%	6 15.4%

График 5.3-т 2012, 2015, 2018, болон 2025 онуудад бизнес эрхлэгчдийн зүгээс төрийн байгууллагад авлига өгөх тохиолдлыг хэрхэн эргэн санаж байгааг харуулсан байна. "Сүүлийн нэг сард" бизнесийн орчинд авлига өгөх тохиолдлын хувь дурдсан онуудад тууштай буурсаар 2025 онд 5.2 хувь болсон нь авлигын тохиолдлын хэмжээ буурсныг харуулж болох юм. Ийм байдлаар, сүүлийн жил гаруй орчимд бүхий л хугацаанд авлигын тохиолдлууд нэгэн адил буурсан нь авлигын цар хэмжээг цаг хугацааны ойрын мөчлөгт багассан болохыг илэрхийлж байна. Мөн, "тийм тохиолдол хэзээ ч гаргаагүй" гэсэн хариулт нь 2025 онд 31 хувь болж өссөнөөр үүнийг батлахын зэрэгцээ, бизнесийнхэн авлигын соёлд дасан зохицох бус, харин түүнд илүү сөрөг хандах байдлыг харуулж байна.

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Зураг 5.3. Бизнесийн салбарт аль нэгэн компани төрийн байгууллагад авлига өгсөн тохиолдол



Хүснэгт 5.3-харахад, үйлчилгээ, худалдаа, үйлдвэрлэлийн салбарт авлигын тохиолдол цаг хугацааны харьцангуй саяханд буюу ойрхон илэрч байна. Харин, нэг жилээс өмнө буюу цаг хугацаа алслах тусам барилга, уул уурхай, хөдөө аж ахуй зэрэг салбар дахь тохиолдлын бүртгэл нэмэгдэж байж болох юм.

Хүснэгт 5.3. Танай бизнесийн салбарт аль нэгэн компани төрийн байгууллагад авлига өгсөн тохиолдол байна уу?

	Сүүлийн нэг сард	Өнгөрсөн 2-3 сард	4-6 сарын өмнө	7-11 сарын өмнө	1 жилээс өмнө	Тийм тохиолдол хэзээ ч гараагүй	Мэдэх- гүй
Үйлчилгээ	5 4.3%	0 0.0%	4 3.5%	1 0.9%	6 5.2%	45 39.1%	54 47.0%
Худалдаа	7 9.0%	7 9.0%	2 2.6%	2 2.6%	4 5.1%	20 25.6%	36 46.2%
Үйлдвэрлэл	2 3.4%	1 1.7%	1 1.7%	2 3.4%	1 1.7%	21 35.6%	31 52.5%
Барилга угсралт	0 0.0%	2 6.7%	1 3.3%	0 0.0%	4 13.3%	6 20.0%	17 56.7%
Уул уурхай	0 0.0%	0 0.0%	0 0.0%	0 0.0%	1 14.3%	3 42.9%	3 42.9%
ХАА	0	0	0	0	3	0	4

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

	0.0%	0.0%	0.0%	0.0%	42.9%	0.0%	57.1%
Эрчим хүч	0	0	0	0	1	0	1
	0.0%	0.0%	0.0%	0.0%	50.0%	0.0%	50.0%
Дэд бүтэц, зам	0	1	0	0	0	1	0
	0.0%	50.0%	0.0%	0.0%	0.0%	50.0%	0.0%
Мэдээлэл технологи, харилцаа	1	0	0	0	1	2	4
	12.5%	0.0%	0.0%	0.0%	12.5%	25.0%	50.0%
Бусад	3	4	2	0	1	10	20
	7.5%	10.0%	5.0%	0.0%	2.5%	25.0%	50.0%

Сүүлийн нэг сараас нэг жилийн өмнөх хугацаанд авч үзвэл, 300 саяас нэг тэрбум төгрөгийн хөрөнгийн эргэлттэй байгууллагуудын 9.8 хувь нь нэг жилийн өмнө, нэгээс 2.5 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй байгууллагуудын 6.4 хувь нь сүүлийн нэг сард, мөн 2.5–аас 5 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй байгууллагуудын 9.7 хувь нь нэг жилийн өмнө авлига өгсөн тохиолдол байгаа нь хамгийн өндөр үзүүлэлтүүд болж байна. Энэ нь дунд болон харьцангуй том хэмжээний хөрөнгийн эргэлттэй байгууллагуудын хувьд авлигын тохиолдлууд илүү байсныг харуулж байна.

Хүснэгт 5.4. Танай бизнесийн салбарт аль нэгэн компани төрийн байгууллагад авлига өгсөн тохиолдол байна уу?

	Сүүлийн нэг сард	Өнгөрсөн 2-3 сард	4-6 сарын өмнө	7-11 сарын өмнө	1 жилээс өмнө	Тийм тохиолдол хэзээ ч гараагүй	Мэдэхгүй
300,000,000 төгрөг-с бага	4 2.9%	5 3.6%	5 3.6%	1 0.7%	6 4.3%	59 42.8%	58 42.0%
300,000,000 төгрөг-с - 1,000,000,000	5 6.1%	6 7.3%	3 3.7%	1 1.2%	8 9.8%	23 28.0%	36 43.9%
1,000,000,000 төгрөг-с - 2,500,000,000	3 6.4%	2 4.3%	2 4.3%	2 4.3%	3 6.4%	9 19.1%	26 55.3%
2,500,000,000 төгрөг- 5,000,000,000	3 9.7%	1 3.2%	0 0.0%	0 0.0%	3 9.7%	7 22.6%	17 54.8%
5,000,000,000 төгрөгөөс дээш	2 4.5%	1 2.3%	0 0.0%	1 2.3%	2 4.5%	10 22.7%	28 63.6%


Бизнес эрхлэгчдийн хувьд бизнес эрхлэлттэй холбоотой төрийн үйлчилгээ авах үед алдагдалд орох, үр ашиггүй хөрөнгө нөөцийг зарцуулах зэрэг эрсдэлүүдийн талаар дээр авч үзлээ. Харин, тэдний хувьд өөрсдийн бараа, үйлчилгээг төрийн байгууллагад нийлүүлэх, хүргэх нь чухал зорилтуудын нэг

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

бөгөөд үүний тулд худалдан авах ажиллагаанд буюу сонгон шалгаруулалтад амжилттай оролцох хэрэгтэй. Төрийн албан дахь авлигын үндсэн эрсдэл бий болох үйл явцуудын нэг нь төрийн худалдан авах ажиллагаа билээ.

График 5.4-т сүүлийн арав гаруй жилийн хугацаанд төрийн худалдан авах ажиллагааны хүрээнд авлигын тохиолдол тууштай буурч буй үр дүн бий болжээ. Юуны өмнө, төрийн худалдан авах ажиллагаа болон гэрээ байгуулах үйл явцад авлига **үргэлж тохиолддог** гэж үзэх хандлага жилээс жилд буурч, 2012 онд 47 хувь байсан бол 2025 онд 20.5 хувь болжээ. Энэ нь төрийн худалдан авалт, тендерийн ил тод байдал тодорхой хэмжээнд сайжирч, бизнес эрхлэгчдийн дунд авлигын талаарх сөрөг хүлээлт буурч байгааг харуулж байна. Ерөнхийдөө, энэ үйл явцад авлигын тохиолдол заримдаа болон хааяа гардаг гэсэн хариултуудын хувь хэмжээ буурч, ер нь гардаггүй гэсэн хариултын хувь өмнө 2018 оныхоос тав дахин нэмэгдсэн байна. “Хааяа нэг” гардаг гэсэн хариултын хувь хэмжээ 2012 онд 11.8 хувь, 2018 онд 13.3 хувь, 2018 онд 15.5 хувь болж тасралтгүй өссөн бол 2025 онд 10.1 хувь болж буурсан байна. Энэ нь тухайн цаг үед төрийн худалдан авах ажиллагаанд авлига өсөн нэмэгдсэн ч, сүүлийн жилүүдэд багассан гэсэн зураглалыг харуулж байна.

Зураг 5.4. Төрийн худалдан авах ажиллагаа (тендер) болон гэрээ байгуулах ажиллагаанд авлига тохиолддог эсэх талаар




Судалгааны дараагийн үр дүн төрийн албан дахь авлигын бизнест үзүүлэх үр нөлөөний талаар танилцуулна. 2012–2018 онд бизнес эрхлэгчдийн дийлэнх нь төрийн албан дахь авлига тэдний бизнест шууд нөлөөлдөг гэж үзэж байсан бол энэ хандлага 2018 оноос буурч эхэлсэн байна. Тухайлбал, 2018 онд энэ

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

талаарх “үгүй” гэсэн хариулт анх удаа “тийм” гэсэн хариултыг 7 хувиар давж, бизнес эрхлэгчдийн дунд авлигын шууд нөлөөллийг үгүйсгэх байр суурь давамгайл болсон байна. 2025 онд “тийм” гэж үзсэн бүлэг эрс буурч 22% болсон нь анхны түвшнээс хоёр дахин багассан үзүүлэлт юм. Үүний зэрэгцээ “мэдэхгүй” гэсэн тодорхой бус байр суурь эрс өсөж 36%-д хүрсэн нь авлигын нөлөөллийн талаарх ойлголт улам бүр тодорхой бус болсон өөрчлөлтийг харуулж байна.

Зураг 5.5. Төрийн албан дахь авлига бизнест нь нөлөөлж байгаа эсэх




Энэ судалгааны хүрээнд сүүлийн үед Засгийн газраас хэрэгжүүлсэн авлигын эсрэг бодлого, үйл ажиллагааны үр дүнгийн талаар бизнес эрхлэгчдийн санал бодлыг тандсан юм. Юуны өмнө, сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн бодлого үйл ажиллагааны талаарх судалгаанд оролцогчдын мэдлэгийн түвшнийг тодруулсан. Энэ хугацаа нь, 2024 оны УИХ-ын сонгуулийн дараа байгуулагдсан засгийн газар болон түүний өмнөх засгийн газрын бодлого үйл ажиллагааг хамарч байна. Тухайлбал, МУЗГ-аас 2023 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарлаж, түүний хүрээнд “5 Ш” ажиллагааг зарлаж байсан ба эдгээр нь 1) *Шүгэл* – шүгэл үлээгчийг хамгаалах, урамшуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх; 2) *Шүүр* – хууль зөрчсөн, ашиг сонирхлын зөрчилтэй албан тушаалтныг илрүүлэн цэвэрлэх; 3) *Шувуу* – авлига, албан тушаалын хэрэгт холбогдсон, гадаадад зугтсан этгээдийг эргүүлэн авчрах; 4) *Шилжүүлэн авах* – гадаад, оффшор дахь хууль бус хөрөнгийг буцаах; 5) *Шил* – төрийн үйл ажиллагааг цахимжуулж, ил тод болгох зорилготой юм.

Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн засгийн газраас авч хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааны талаарх мэдлэг хангалтгүй байгаа ба тэдний талаас илүү хувь нь энэ талаар маш муу мэдлэгтэй эсвэл мэдэхгүй байна.


БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Зураг 5.6. Засгийн газраас сүүлийн 2 жилд хэрэгжүүлж буй авлигын эсрэг үйл ажиллагааны талаар хэр сайн мэдэх вэ?



Дээрх бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлсэн засгийн газрыг болон 2024 оны УИХ-ын сонгуулийн үр дүнд байгуулагдсан Засгийн газрын авлигын эсрэг бодлого үйл ажиллагааны талаарх үнэлгээ бас доогуур харагдаж байна. Бизнес эрхлэгчдийн 40 орчим хувь нь дээрх үйл ажиллагаа авлигыг бууруулахад огт үр нөлөөгүй гэсэн санал бодолтой явдаг байна. Мөн судалгаанд оролцсон дөрвөн хүн тутмын нэг нь үр дүн багатай гэсэн хариулт өгчээ.

Зураг 5.7. Өмнөх Засгийн газрын хэрэгжүүлж байсан авлигын эсрэг арга хэмжээ Монгол улсын авлигыг бууруулахад хэр үр дүнтэй байсан вэ?



Өмнөх Засгийн газар 2025 оны 6 сарын эхэнд авлигатай холбоотой асуудлаар, тухайлбал, түүний хүүгийн бусдад бэлэглэсэн үнэтэй бэлэг түүний хууль бус орлогын эх үүсвэрээс гаралтай байж болох талаарх олон нийтийн эсэргүүцэлтэй нүүр тулж. Улмаар, 2025 оны 7 сард шинэ Засгийн газрын тэргүүнээр Г.Занданшатар тодорч, өөрийн кабинетыг байгуулсан юм. Дараах асуулт нэг талаас, өмнөх Засгийн газрын байгуулагдсан цагаас хойших авлигын эсрэг бодлогод, үйл ажиллагаанд үнэлгээ өгч буй юм.

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Зураг 5.8. Засгийн газраас хэрэгжүүлж буй авлигын эсрэг арга хэмжээний дүнд танай салбарын авлигын орчин нэг жилийн өмнөхтэй харьцуулбал хэр өөрчлөгдсөн бэ?



Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн гуравны нэг нь авлигын нөхцөл байдал хэвээр байна гэсэн бол 40 гаруй хувь нь энэ талаар мэдээлэл байхгүй байна.

Дараагийн асуулт Монгол улс дахь авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт, үр нөлөө, өндөр түвшний авлигын асуудалд чиглэж байна. Бизнес эрхлэгчдийн зүгээс Монгол улсад өнөөдөр хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа авлигын эсрэг хууль тогтоомжуудын үр нөлөө хангалтгүй гэсэн төсөөлөлтэй явдаг аж. Судалгаанд оролцсон таван бизнес эрхлэгч тутмын нэг нь огт үр нөлөө байхгүй гэсэн бол гурван бизнес эрхлэгч тутмын нэг нь бага зэрэг хэмээн үнэлсэн байна.

Зураг 5.9. Таны бодлоор Бизнесийн орчныг ил тод, авлигаас ангид болгоход хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжууд хэр үр нөлөөтэй байна вэ?




Мөн тэдний судалгаанд хамрагдсан хоёр бизнес эрхлэгч тутмын нэг, бүр тэдний талаас ч илүү хувь нь Засгийн газар авлигын асуудалд холбогдсон төрийн өндөр албан тушаалтнуудтай бодитой, шударга хариуцлага тооцож чадахгүй

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН


байгаа гэж хариулсан байна. Мөн 18 орчим хувь нь хаа нэг ийм асуудалд хариуцлага тооцож буй гэжээ.

Зураг 5.10. Авлигад өртсөн төрийн албан тушаалтнуудад Засгийн газар бодитой, шударгаар хариуцлага тооцож чаддаг уу?



Өндөр түвшний авлигын бизнест үзүүлэх нөлөөний талаарх асуултад судалгаанд хамрагдсан гурван бизнес эрхлэгчийн нэг нь энэ талаар мэдэхгүй гэж хариулсан бол 26.6 хувь нь энэ төрлийн авлига тэдний эрхэлж буй бизнест огт нөлөө үзүүлэхгүй болохыг хэлжээ. Өндөр түвшний авлигын бизнест ихээхэн нөлөөлөл үзүүлэх байдал нь одоогийн бизнес эрхлэгчдийн 25 орчим хувийг эзэлж байна.

Зураг 5.11. Өндөр албан тушаалтны мөнгөн дүн ихтэй авлига таны бизнест хэр зэрэг нөлөөлж байна вэ?




Өндөр албан тушаалтны их хэмжээний авлигын бизнест үзүүлэх нөлөөллийг сүүлийн арван жилд тоймлон, тухайлбал 2015, 2018, болон энэ жилийн байдлаар харвал, нэг чиглэлд шууд тодорхойлоход хүндрэл байна. Өөрөөр хэлбэл, энэ төрлийн авлига тодорхой хэсгийн бизнест үзүүлэх нөлөөллийн жингээ алдаагүй байна гэж болох юм. Үүний бизнест үзүүлэх нөлөө маш их хэмээн хариулсан бүлгийн сүүлийн арван жилд ойролцоо байсны дээр дорвитой өөрчлөлт ороогүй байна. Харин, ихээхэн хэмжээнд нөлөөлдөг гэж үзэх нь хувь хэмжээний хувьд нэг

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН


дахин буурсан дүн гарсан бол эргээд бага зэрэг нөлөөлдөг бүлгийн хувь хэмжээ өөрчлөгдөөгүй гэж болно.

Зураг 5.12. Өндөр албан тушаалтны мөнгөн дүн ихтэй авлига таны бизнест хэр зэрэг нөлөөлж байна вэ?



Ерөнхийдөө, авлига нь хэлбэрийн хувьд хүмүүсийн хоорондын нийгмийн харилцааны нийтлэг илрэх зүйл болов уу, эсвэл илүү зохион байгуулалттай бүлгийн хэлбэрээр илүү хэрэгжиж байна уу хэмээн үзвэл манай нийгэмд аль аль хэлбэрээр нэгэн зэрэг, бас эн тэнцүү хэрэгжиж буй зүйл гэж болохоор байна.

Зураг 5.13. Таны бодлоор төрийн авлига хувь хүмүүсийн хоорондын харилцааны хүрээнд эсвэл зохион байгуулалттай бүлэглэлийн хэмжээнд очсон уу?




БҮЛЭГ 6. ХУВИЙН ХЭВШИЛ ДЭХ АВЛИГА

2018 онд бизнесийн салбарын авлигын түвшнийг тодорхойлох судалгаанд оролцогчдын 27.6 хувь нь хувийн хэвшилд авлига байхгүй гэж үзэж байсан бол 2025 оны судалгаанд энэ үзүүлэлт 16.6 хувь болж буурсан байна. Өөрөөр хэлбэл, “авлига байхгүй” гэсэн хариултын хувь хэмжээ 2018 онтой харьцуулахад 9.0 хувиар буурчээ. Энэ нь бизнес, хувийн хэвшлийн салбарт авлига нэмэгдэх хандлага ажиглагдаж буйг харуулж байна.

Нөгөө талаас, “авлига маш их, их байна” гэсэн үнэлгээ 2018 онд 26.6 хувь байсан бол 2025 онд 33.7 хувь болж, 7.1 хувиар өссөн байна. Энэ нь бизнесийн салбарын орчинд авлигын талаарх сөрөг үнэлгээ нэмэгдэж, авлигын түвшин өсөх чиг хандлага давамгайлж байгааг илтгэж байна.


Иймээс судалгааны дүнгээс үзэхэд, 2018 оноос 2025 оны хооронд бизнесийн орчинд авлига байхгүй гэж үзэх хандлага буурч, харин авлига их байна гэж үзэх үнэлгээ өссөн нь авлига бизнес, хувийн хэвшлийн салбарт авлига нэмэгдэх хандлагатай байгааг харуулж байна (Зураг 6.1).

Зураг 6.1. Хувийн хэвшил дэх авлигын үнэлгээ



БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Зураг 6.2. Хувийн хэвшлийн салбар дахь авлигын тархалтыг тухайн байгууллагын эргэлтийн хөрөнгөөр харьцуулан харууллаа



Тухайн бизнесийн байгууллагын эргэлтийн хөрөнгөний хэмжээ бага тохиолдолд авлига дунд зэрэг гэж үзэж, харин эргэлтийн хөрөнгө дундаас дээш, бүр том аж ахуйн нэгжийн хувьд авлига их, маш их гэж үзэх нь 45 хувиас өндөр байна.

Хүснэгт 6.1. Хувийн хэвшлийн тендерийн болон гэрээ байгуулах ажиллагаан дахь авлигын түвшин

	9 сар 2016	9 сар 2017	9 сар 2018	9 сар 2025
Байнга	12,4 %	13,3 %	9,7 %	12,0 %
Нэлээд их	23,6 %	21,2 %	18,5 %	26,9 %
Хааяа	31,2 %	37,6 %	31,5 %	17,7 %
Хэзээ ч гардаггүй	13,6 %	8,2 %	12,7 %	13,7%
Мэдэхгүй	19,1 %	19,7 %	27,6 %	29,1 %

Хувийн хэвшлийн салбарт тендерийн болон гэрээ байгуулах үйл ажиллагаанд авлигын түвшнийг тодорхойлоход, “авлига байнга болон нэлээд их хэмжээнд байна” гэж үзсэн хувь 2016 оны 9 дүгээр сард 36.0 хувь, 2017 оны 9 дүгээр сард 34.5 хувь, 2018 оны 9 дүгээр сард 28.2 хувь байсан бол 2025 оны 9 дүгээр сард 38.9 хувьд хүрчээ. Ийнхүү 2018 оноос хойш уг үзүүлэлт 10.7 хувиар өссөн нь хувийн хэвшлийн салбар дахь авлигын түвшин нэмэгдсэнийг харуулж байна.


БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Хүснэгт 6.2. Хувийн хэвшлийн тендерийн болон гэрээ байгуулах ажиллагаа дахь авлигын түвшнийг бизнесийн жилийн эргэлтийн хөрөнгөөр харьцуулан харуулбал:

Эргэлийн хөрөнгө	Байнга	Нэлээд их	Хааяа	Хэзээ ч гардаггүй	Мэдэхгүй
300,000,000 төгрөг-с бага	17.4%	27,5 %	17,4 %	11,6 %	26.1 %
300,000,000 төгрөг-с – 1,000,000,000	7,3 %	24,4 %	18,3 %	22.0%	28.0 %
1,000,000,000 төгрөг-с – 2,500,000,000	10.6 %	21,3 %	21,3 %	10,6 %	36,2%
2,500,000,000 төгрөг- 5,000,000,000	6,5 %	22,6 %	25,8%	25,8%	19.4 %
5,000,000,000 төгрөгөөс дээш	11,4 %	43,3 %	9,1 %	13,7 %	36.4 %

Хувийн хэвшлийн тендерт оролцох болон гэрээ байгуулах үйл ажиллагааны явцад эргэлтийн хөрөнгө өндөр, том аж ахуйн нэгжийн хувьд авлигын түвшин өндөр байх дүр зураг харагдаж байна.

Зураг 6.3. Бизнесийн салбаруудад үйл ажиллагаа явуулахад тохиолдох авлигын тархалт



Бизнесийн салбарт авлига байнга тохиолддог гэж үзсэн иргэдийн түвшин 2018 оноос хойш 2.3 хувиар нэмэгдсэн байна. Мөн “нэлээд их” гэж үнэлсэн хандлага 2018 онтой харьцуулахад 8.4 хувиар өссөн нь энэ салбарт авлигын түвшин нэмэгдэж буйг харуулж байна. Эдгээр үзүүлэлтээс харахад бизнесийн орчинд авлигын асуудал буурах бус харин нэмэгдэх хандлагатай байгаа нь илэрхий байна. Энэ нь бизнесийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хяналт шалгалтыг сайжруулах, авлигын эсрэг бодлого, хууль эрх зүйн хэрэгжилтийг бэхжүүлэх шаардлагатайг харуулж байна.


БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Хүснэгт 6.4. Бизнесийн салбаруудад үйл ажиллагаа явуулахад тохиолдох авлигын тархалтыг салбараар харьцуулан харуулбал:

Салбар	Байнга	Нэлээд их	Хааяа	Хэзээ ч гардаггүй	Мэдэхгүй
Үйлчилгээ	2.6	9.5	25.9	36.2	25.9
Худалдаа	6.4	12.8	28.2	30.8	21.8
Үйлдвэрлэл	5.2	3.4	29.3	34.5	27.6
Барилга угсралт	0	6.7	43.3	13.3	36.7
Уул уурхай	0	0	28.6	42.9	28.6
ХАА	0	0	0	28.6	71.4
Эрчим хүч	0	0	0	50	50
Дэд бүтэц, зам	0	50	0	50	0
Мэдээлэл технологи, харилцаа	0	25	25	37.5	12.5
Бусад	0	23.1	33.3	33.3	10.3

Авлигын тархалтыг бизнесийн салбараар харьцуулан харуулбал дэд бүтэц, замын салбарт авлига нэлээд их байна (50 хувь) гэж үзжээ. Харин барилга угсралт, уул уурхай, үйлдвэрлэл, худалдааны салбарт хааяа гардаг гэж үзжээ.

Зураг 6.4. Бизнесийн салбарын татвараа хууль ёсны дагуу төлөх байдал



Бизнесийн байгууллагууд татвараа хууль ёсны дагуу төлөх байдалд эерэг өөрчлөлт гарчээ. Тухайлбал, 2018 онд бүх байгууллага татвараа хуулийн дагуу төлдөг байсан нь 15.8% байсан бол 2025 онд 37.9% болж, 22.1 хувиар өссөн байна. Энэ нь бизнес эрхлэгчдийн дунд татвар төлөлт сайжирсан, хууль журмыг мөрдөх хандлага нэмэгдсэнийг харуулж байна. Эдгээр үр дүнгээс харахад татвар төлөлтийн байдал сайжирсан нь бизнесийн орчинд ил тод байдлыг нэмэгдүүлж, татварын сахилга батыг дээшлүүлэх боломжтой байгааг илтгэнэ. Энэ хандлагыг цаашид тогтвортой хадгалах, татвар төлөлтийн талаарх мэдээллийг олно нийтэд

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН


түгээх, шилдэг татвар төлөгчдийг урамшуулах сурталчлах арга хэмжээг үргэлжлүүлэх шаардлагатай байна.

Хүснэгт 6.5. Авлигад өртөмхий салбарууд: олон сонголттой


№	Салбарууд	2016-9 сар	2017-9 сар	2018-9 сар	2025-9сар
1.	Уул уурхай, ашигт малтмал	48,8 %	55,8 %	58,2 %	39,1 %
2.	Шүүх цагдаа прокурор	-	-	-	38.5 %
3.	Банк санхүү	13,9 %	15,2 %	13,9 %	32.2 %
4.	Гааль татвар хяналт	-	-	-	31.0 %
5.	Барилга, дэд бүтэц	41,2 %	35,8 %	42,1 %	29.0 %
6.	Төрийн худалдан авалт	-	-	-	24.4 %
7.	Боловсрол	-	-	-	17.8 %
8.	Эрүүл мэнд	-	-	-	17.8 %
9.	Зам, тээвэр	-	-	-	15.5 %
10.	Эрчим хүч шатахуун	-	-	-	14.9 %
11.	Үйлдвэрлэл	6.7 %	5,2 %	5,2 %	8.0 %
12.	Худалдаа	10,9 %	7.0 %	9,1 %	6.3 %
13.	Бусад салбар	-	-	-	1,1 %
14.	Хэлж мэдэхгүй байна	-	-	-	17.8 %

Судалгаанд хамрагдсан салбаруудын хувьд 2016–2025 оны хооронд авлигын түвшинд зарим өөрчлөлт гарсан байна. Тухайлбал, уул уурхай, ашигт малтмалын салбар 2016–2018 онд өсөх хандлагатай байсан (48.8% - 58.2%), харин 2025 онд 39.1% болж буурсан нь авлигын түвшинд тодорхой хэмжээний бууралт гарсныг илтгэнэ. Харин банк, санхүүгийн салбар 2016–2018 онд тогтвортой (13.9–15.2%) байсан бол 2025 онд 32.2% болж эрс өссөн нь энэ салбарт авлигын эрсдэл нэмэгдсэнийг харуулж байна. Барилга, дэд бүтцийн салбар 2016–2018 онд харьцангуй өндөр түвшинд (35.8–42.1%) байсан ч 2025 онд 29% болж буурсан байна. Үйлдвэрлэл болон худалдааны салбарууд харьцангуй тогтвортой бөгөөд бага түвшний авлигын тохиолдолтой байна. Жишээлбэл, үйлдвэрлэл 2016 онд 6.7% байсан бол 2025 онд 8.0% болж үл ялиг өссөн, худалдаа 2016 онд 10.9% байснаа 2025 онд 6.3% болж буурчээ. 2025 онд шинээр орсон салбарууд болох шүүх, цагдаа, прокурор (38.5%), гааль, татвар, хяналт (31.0%), төрийн худалдан авалт (24.4%), боловсрол болон эрүүл мэнд (17.8%) хувьтай байгаа нь эдгээр салбарт авлигын эрсдэл байгааг илтгэж байна. Хүснэгт 6.5 аас харна уу.

Зураг 6.5. Төрийн худалдан авах ажиллагаанд оролцдог эсэх




Зураг 6.6. Таны бодлоор төрийн худалдан авах ажиллагаанд хамаарал бүхий этгээд оролцож, нөлөөлдөг эсэх



Зураг 6.7. Төрийн худалдан авах ажиллагаанд оролцох итгэл

Өмнөх Засгийн газрын үед худалдан авах ажиллагаанд итгэж оролцох уу?




Төрийн худалдан авах ажиллагаатай холбоотой дээрх багц асуултыг дүгнэн үзвэл бизнесийн салбарынхан төрийн худалдан авах ажиллагаанд төдийлөн оролцдоггүй байна. Цаашид оролцох сонирхол байхгүй байна.

БҮЛЭГ 7. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА


Авлигын хэрэгт хэн хариуцлага хүлээх ёстой талаар нийгэмд зөрүүтэй байр суурь, санал зөрөлдөөн өрнөсөөр ирсэн. Харин энэхүү судалгаанд оролцогчид авлигын хэрэгт хэн хариуцлага хүлээх нь зүйтэй гэж үзэж буй талаарх өөрсдийн байр суурийг дараах байдлаар илэрхийлсэн байна

Зураг 7.1. Авлигын хэрэгт хэн хариуцлага хүлээх нь зохистой талаарх бодомжийн үнэлгээ



Судалгааны үр дүнгээс харахад дийлэнх олонх буюу 75.4 хувь нь авлигын хэрэгт өгсөн болон авсан этгээд хоёулаа хариуцлага хүлээх шаардлагатай гэж үзжээ. Үүний зэрэгцээ 11.1 хувь нь зөвхөн авсан этгээдэд хариуцлага тооцох нь зүйтэй гэсэн байр суурьтай байсан бол 12.6 хувь нь энэ асуудлаар тодорхой санал илэрхийлээгүй байна. Бизнес эрхлэгчдийн дийлэнх нь (75.4%) авлигын хэрэгт өгсөн авсан аль аль нь ижил түвшинд хариуцлага хүлээх ёстой гэж үзсэн нь нийгэмд шударга ёсыг эрхэмлэх үзэл давамгайл байгааг харуулж байна. Харин зөвхөн авсан этгээдэд хариуцлага тооцох ёстой гэж үзсэн хувь (11.1%) болон тодорхой санал илэрхийлээгүй бүлэг (12.6%) харьцангуй бага байгаа нь иргэдийн дунд авлигын эсрэг ойлголт харьцангуй нэг чиглэлд төвлөрч буйг илтгэж байна.

Зураг 7.2. Төрийн албан дахь авлига буурснаар бизнесийн орчинд үзүүлэх нөлөө




БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Төрийн албанд авлига оршин байгаа нь бизнесийн орчинд сөргөөр нөлөөлж, татвар, зөвшөөрөл болон бусад үйл ажиллагааны түвшинд олон талын хүндрэл үүсгэх эрсдэлтэй. Иймээс 2016 оноос өнөөг хүртэл бизнес эрхлэгчдийн дунд төрийн албан дахь авлигыг бууруулбал бизнесийн орчин сайжирч, орлого нэмэгдэх боломжтой гэсэн хандлага тогтвортой хадгалагдаж иржээ. 2016 оноос өнөөг хүртэл бизнес эрхлэгчдийн дунд төрийн албанд буй авлига нь бизнесийн орчныг доройтуулах, татвар, зөвшөөрөл болон бусад үйл ажиллагаанд хүндрэл учруулах гол хүчин зүйлсийн нэг гэж үзэх хандлага тогтвортой хадгалагдаж байна. Үүний зэрэгцээ, төрийн албаны авлигад хяналт тавьж, бууруулах нь бизнесийн орчныг сайжруулж, бизнесийн байгууллагуудын орлого өсөх боломжийг нэмэгдүүлэх гол нөхцөл гэж харж байгаа нь илэрхий байна.

Судалгааны дүнгээс харахад бизнесийн байгууллагууд авлигатай тэмцэх чиглэлээр дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлдэггүй нь харагдаж байна. Тухайлбал, судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн ердөө 19.7 хувь нь авлигатай тэмцэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулдаг гэж хариулсан бол нийт байгууллагын 54.6 хувь нь энэ чиглэлээр ямар нэгэн ажил огт зохион байгуулдаггүй болохоо илэрхийлсэн байна. Зураг 7.3-аас үзнэ үү.

Зураг 7.3. Бизнесийн байгууллагуудын авлигын эсрэг хийж буй үйл ажиллагаа, арга хэмжээ



Судалгааны дүнгээс харахад бизнесийн байгууллагуудын дийлэнх нь авлигатай тэмцэх чиглэлээр дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлдэггүй байна. Энэ нь байгууллагын дотоод засаглал сул, авлигын эсрэг бодлого, журам, соёл төлөвшөөгүй байгааг харуулж байна. Ийм нөхцөлд бизнесийн орчинд шударга өрсөлдөөн алдагдаж, авлигын эрсдэл даамжрах магадлал өндөр юм.


Хүснэгт 7.1. Бизнесийн байгууллагын авлигатай тэмцэх чиглэлээр авсан арга хэмжээ

	9 сар 2016	9 сар 2017	9 сар 2018	9 сар 2025
Тийм	14,2 %	15.2 %	17,3 %	19,7 %
Үгүй	72,4 %	73.0 %	65,8 %	54,6 %
Мэдэхгүй	13,3 %	11,8 %	17.0 %	25,1 %

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2016 оноос хойш бизнесийн байгууллагууд авлигын эсрэг арга хэмжээ авах санаачилга аажмаар нэмэгдэж байгааг харж болно. Судалгааны явцад зарим байгууллага авлигын эсрэг ажилтнуудын ажлын хариуцлагыг нэмэгдүүлэх, санхүү болон мэдээллийн дотоод систем, хяналтыг сайжруулах зэрэг арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлдэг талаар дурдсан. Тухайлбал, 2016 оны 9-р сард эдгээр арга хэмжээг хэрэгжүүлдэг байгууллагын хувь 14.2 байсан бол 2025 оны 8-р сард 19.7 хувь болж 5.5 хувиар нэмэгдсэн нь хүснэгт 7.1-ээс харагдаж байна. Үүний зэрэгцээ авлигын эсрэг арга хэмжээ авч ажилладаггүй байгууллагын хувь 2016 оны 9-р сараас 2025 оны 9-р сар хүртэл тогтмол буурч, 72.4 хувиас 54.6 хувь болжээ. Энэ нь бизнесийн байгууллагууд шударга ёсыг бэхжүүлэх, авлигын эсрэг үйл ажиллагаанд идэвхтэй оролцох хандлага тогтвортой нэмэгдэж байгааг илтгэж байна.

Зураг 7.4. Авлигын тохиолдлын талаар мэдээлсэн байдал




Судалгааны үр дүнгээс үзэхэд ихэнх хүмүүс авлигын талаар мэдээлэл өгөөгүй байна. Энэ нь хэд хэдэн шалтгаантай байж болох юм. Тухайлбал, мэдээлэл хаана өгөхөө мэдэхгүй байсан, эсвэл өгсөн мэдээллийг шийдвэрлэхгүй байх вий гэх итгэлгүй байдал зэрэг нь нөлөөлсөн гэж үзэж болно. 2016 оноос 2025 оныг хүртэл харьцуулан харвал 2-3 хувийн хэлбэлзэл байна. Харин 2025 онд мэдээлэл өгсөн байдал 2018 оноос 4,8 хувиар өссөн байна. Мөн зарим бизнес эрхлэгчид нэгэнт авлига өгч ажил нь амжилттай болсон учраас мэдээлэх шаардлагагүй гэж үзсэн байдал ажиглагдсан. Судалгааны явцад зарим бизнес эрхлэгчид тодорхой эрх, лиценз, зөвшөөрөл авахад тогтсон авлига байгааг дурдаж, “авлига өгөхгүй асуудлыг шийдэх нь бидний бизнес, ашиг орлогод сөргөөр нөлөөлж болох тул дагаад өгч, шийдвэрлүүлэх нь дээр” гэсэн байр суурь илэрхийлсэн байна. Мөн судалгаанд оролцогчдын зарим хэсэг нь

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

мэдэхгүй байгаагаа илэрхийлсэн нь авлигын мэдээлэл өгөхөд оролцогчдын мэдлэг, итгэлцэл хангалтгүй байгааг харуулж байна. Энэ нь авлигын мэдээллийг хүлээн авах суваг, мэдээллийн нууцлал, ирсэн гомдлын мөрөөр яаралтай арга хэмжээ авах, эргэн мэдэгдэх зэрэг арга хэмжээний үр дүнг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Зураг 7.5. Мэдээлсэн бол үр дүнд хүрсэн эсэх




Авлигын талаар мэдээлэл өгсөн ч үр дүнд хүрдэггүй гэсэн хандлага 2016 оноос 2018 оны хооронд тогтвортой өссөн байна. Тухайлбал, 2016 онд ийм байр суурьтай байсан хүмүүсийн хувь 43.3 хувь байсан бол 2018 онд 52.9 хувьд хүрч, ойролцоогоор 9 хувиар өсжээ. Энэ нь тухайн үед иргэдийн дунд мэдээлэл өгсөн ч бодит өөрчлөлт гарахгүй гэсэн итгэл сул байсныг илтгэнэ.

Харин 2025 онд энэ үзүүлэлт 31.3 хувь болж буурсан нь нэг талаас эерэг мэт боловч бодит байдалд мэдээлэл өгсөн эсэхээ тодорхой хэлээгүй буюу “мэдэхгүй/хариулаагүй” гэж сонгосон иргэдийн эзлэх хувь 56 хувь болж огцом өссөнтэй холбоотой байна.

Эндээс харахад авлигын талаар мэдээлэл өгсөн ч үр дүнд хүрэхгүй гэсэн эргэлзээтэй хандлага хэвээр үлдэж, харин тодорхой байр суурь илэрхийлэхээс зайлсхийх, итгэлгүй байдал улам нэмэгдсэн байна. Энэ нь авлигын мэдээлэл авах системийн ил тод байдал, мэдээллийн дагуу түргэн шуурхай шийдвэрлэх үр нөлөө хангалтгүй байгаагийн илрэл гэж үзэх үндэстэй.

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Зураг 7.6. Авлигатай тэмцэх журам, бодлого байгаа эсэх




Сүүлийн жилүүдэд бизнесийн байгууллагууд дотоод журам, дүрэмдээ авлигаас ангид байх зарчмыг тусгах хандлага нэмэгдэж буйг судалгааны дүн харуулж байна. Тухайлбал, 2018 оны 9-р сард нийт байгууллагын 20.0 хувь нь энэ чиглэлээр тодорхой заалт оруулсан байсан бол 2025 оны 9-р сарын байдлаар уг үзүүлэлт 6.8 хувиар өсч, 26.9 хувь болсон байна. Энэ нь байгууллагууд өөрийн үйл ажиллагаанд шударга ёсыг бэхжүүлэх, санхүүгийн хариуцлага, ил тод байдал, хүний нөөцийн сонгон шалгаруулалтын шударга байдал зэрэг асуудалд анхаарч, авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд дотоод дүрэм журмаа шинэчилж буйг харуулж байгаа бөгөөд эерэг өөрчлөлт гэж дүгнэж болно.

Цаашид бизнесийн байгууллагуудын авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг улам бэхжүүлэхийн тулд сургалт, мэдээлэл, сурталчилгааг тогтмол зохион байгуулах, гарын авлага болон богино хэмжээний видео контент бэлтгэн түгээх, шилдэг аж ахуйн нэгжийн шалгаруулалтад авлигын эсрэг хүчин чармайлтыг харгалзан үзэх зэрэг олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой юм.

Бизнес эрхлэгчид болон төрийн албаны түвшинд шударга ёсыг бэхжүүлэхэд хамгийн том саад болж буй хүчин зүйл нь авлига гэдэгт бизнесийн байгууллагын төлөөллийн ойлголт нэгджээ. Гэвч авлигатай тэмцэх олон боломжит арга зам бий бөгөөд энэ талаар судалгаанд оролцсон аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөлөл өөрсдийн чухал гэж үзэж буй хамгийн оновчтой арга хэмжээг сонгон илэрхийлсэн байна.

Зураг 7.7. Авлигын эсрэг авч хэрэгжүүлж болох арга хэмжээ



Судалгааны дүнгээс үзвэл бизнесийн байгууллагуудын төлөөлөл авлигатай тэмцэх хамгийн үр дүнтэй арга хэмжээг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: авлига огт өгөхгүй байх, шударга өрсөлдөөний зарчмыг чанд мөрдөх, хуулийн ял шийтгэлийг чангатгах, авлигатай тэмцэх газарт мэдээлэл өгөх, авлигач улс төрч болон төрийн албан хаагчдын эсрэг компанит ажил өрнүүлэх зэрэг арга хэмжээг хамгийн чухал гэж үзсэн байна.

Мөн түүнчлэн авлигын хэргийг ил тод хэлэлцэх, шүүх тогтолцоог бүрдүүлэх, авлигын талаар мэдээлэл өгсөн иргэн, байгууллагыг урамшуулах, авлигын мэдээллийг хүлээн авах тусгай утас болон цахим сувгийн үйл ажиллагааг илүү эрчимжүүлэх зэрэг нь авлигын эсрэг хэрэгжүүлэх оновчтой шийдэл болно гэж үзсэн нь онцлог юм.